



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-12
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-52

1.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	13-59
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	59-61
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	61-62

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 19-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Баатархүү, Б.Бейсен, Д.Рэгдэл;
Чөлөөтэй: О.Батнайрамдал, Х.Болормаа, М.Нарантуяа-Нара, М.Сарнай, Б.Хэрлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Б.Түвшин, М.Энхцэцэг.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны газрын дарга Б.Алимаа, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэг, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Мөнхзул, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Батчимэг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Амгаланзаяа, Цахим бодлого, статистик мэдээллийн хэлтсийн дарга Ч.Энхтуяа, Сайдын зөвлөх Ж.Эрхэмтөгс, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Хөгжлийн нэгдсэн бодлого,

төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Райымбек, Г.Отгонцэцэг, мөн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Чандмань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, мөн яамны Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, Дээд мэргэжлийн боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга Н.Нарангэрэл, Ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсролын зээлийн сангийн Дотоод зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн хэлтсийн дарга Ц.Доржсүрэн, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Бадамжав, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, мөн газрын ахлах шинжээч Э.Оюунсүрэн, Ш.Энхтуяа, Эрүүл мэндийн даатгалын Бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга Н.Эрдэнэбаяр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Их өгөгдөл, судалгааны албаны дарга Г.Дамба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, С.Зулпхар, А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, Б.Найдалаа, Д.Ганмаа, О.Саранчулуун, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар нэгдсэн хуралдаанаас чиглэл өгсөн асуудлаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралттай холбоотой санал:

Б.Найдалаа: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Хүний хөгжил” бодлогын чиглэлд доор дурдсан агуулгатай 1.3

дахь заалт нэмэх:

“1.3.Улсын хөгжлийн тэргүүлэх салбар болсон боловсролын салбарын санхүүжилтийг хүртээмжтэй, тогтвортой өсгөх зорилгоор жил бүр тухайн жилийн Төсвийн тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тооцоолсон дотоодын нийт бүтээгдэхүүний зургаагаас доошгүй хувийг, эсхүл улсын төсвийн нийт зардлын хориос доошгүй хувийг боловсролын салбарт зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа тайлбарлаж, Сангийн яамны Хөгжлийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нэмэлт тайлбар хийв.

Хоёр.Тогтоолын төслийн 2, 3 дугаар хавсралттай холбоотой санал:

Төслийн 2 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал гарсантай холбогдуулан 3 дугаар хавсралт хамт өөрчлөгдөх саналууд

Б.Найдалаа: 2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганын “Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах” гэснийг “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж, “Хамтран хариуцагч” баганын “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэснийг “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж өөрчлөх.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтад доор дурдсан агуулгатай шалгуур үзүүлэлтийн мөр нэмэх:

“1.1.1.1.“Шалгуур үзүүлэлт” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно, “ТХЗ уялдаа” 4.с.1, “Хэмжих нэгж” Индекс, “Суурь түвшин” **Он** 2024, **Түвшин** 2,332.4 (мян.төг), “Зорилтот түвшин” **2026 он** 2025 оны түвшнээс дээгүүр, **2027 он** 2026 оны түвшнээс дээгүүр, **2028 он** 2027 оны түвшнээс дээгүүр, **2029 он** 2028 оны түвшнээс дээгүүр, **2030 он** 2029 оны түвшнээс дээгүүр, “Мэдээллийн эх сурвалж” Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, “Мэдээлэл цуглуулах арга зүй” Статистик тоон мэдээлэл, салбарын тайлан, “Мэдээлэл цуглуулах давтамж” Жил тутам, “Хариуцах байгууллага” Боловсролын яам.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа тайлбарлаж, Сангийн яамны Хөгжлийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны газрын дарга Б.Алимаа нар нэмэлт тайлбар хийв.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Арга зам” баганын “Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах” гэснийг “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж өөрчилж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж нэмэх.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтад доор дурдсан агуулгатай шалгуур үзүүлэлтийн мөр нэмэх:

“1.1.2.2.“Шалгуур үзүүлэлт” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно, “ТХЗ уялдаа” 4.с.1, “Хэмжих нэгж” Индекс, “Суурь түвшин” **Он 2024, Түвшин 2,332.4** (мян.төг), “Зорилтот түвшин” **2026 он 2025 оны түвшнээс дээгүүр, 2027 он 2026 оны түвшнээс дээгүүр, 2028 он 2027 оны түвшнээс дээгүүр, 2029 он 2028 оны түвшнээс дээгүүр, 2030 он 2029 оны түвшнээс дээгүүр**, “Мэдээллийн эх сурвалж” Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, “Мэдээлэл цуглуулах арга зүй” Статистик тоон мэдээлэл, салбарын тайлан, “Мэдээлэл цуглуулах давтамж” Жил тутам, “Хариуцах байгууллага” Боловсролын яам.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын (Бодлогын зорилго): 1 “Хүний хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ” бүлгийн “1.1.Боловсролын чанар хүртээмжийг сайжруулна” хэсэгт доор дурдсан агуулгатай 1.1.3.4 дэх дэд заалт нэмэх:

“1.1.3.4.“Бодлогын үндэслэл” АХ-2.1.34, “Салбар /ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” 71804 Мэргэжлийн боловсрол, “Үр дүн” Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна, “Арга зам” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах, “Үндсэн хариуцагч” Боловсролын яам, “Хамтран хариуцагч” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам”.

Төслийн 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 1.1.3.4 дэх дэд заалт нэмэх:

“1.1.3.4.“Шалгуур үзүүлэлт” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно, “ТХЗ уялдаа” 4.с.1, “Хэмжих нэгж” Индекс, “Суурь түвшин” **Он 2024, Түвшин 2,332.4** (мян.төг), “Зорилтот түвшин” **2026 он 2025 оны түвшнээс дээгүүр, 2027 он 2026 оны түвшнээс дээгүүр, 2028 он 2027 оны түвшнээс дээгүүр, 2029 он 2028 оны түвшнээс дээгүүр, 2030 он 2029 оны түвшнээс**

дээгүүр, “Мэдээллийн эх сурвалж” Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, “Мэдээлэл цуглуулах арга зүй” Статистик тоон мэдээлэл, салбарын тайлан, “Мэдээлэл цуглуулах давтамж” Жил тутам, “Хариуцах байгууллага” Боловсролын яам.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 10
Бүгд: 17
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн 4.2.4.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Авьяасыг тасралтгүй хөгжүүлэх” гэсний дараа “хичээлийн дараах хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтын “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /нийслэл/” мөрний “Суурь түвшин” баганын Түвшин: “76.5” гэснийг “Т* /*Бодитоор тооцох/” гэж, “Зорилтот түвшин” баганын 2026: “78” гэснийг “Т+2 хувь” гэж, 2027: “80” гэснийг “Т+4 хувь” гэж, 2028: “82” гэснийг “Т+6 хувь” гэж, 2029: “84” гэснийг “Т+8 хувь” гэж, 2030: “88” гэснийг “Т+10 хувь” гэж, мөн дэд заалтын “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /аймаг/” мөрний “Суурь түвшин” баганын Түвшин: “97” гэснийг “Т* /*Бодитоор тооцох/” гэж, “Зорилтот түвшин” баганын 2026: “98” гэснийг “Т+2 хувь” гэж, 2027: “99” гэснийг “Т+4 хувь” гэж, 2028: “99” гэснийг “Т+6 хувь” гэж, 2029: “99.5” гэснийг “Т+8 хувь” гэж, 2030: “99.9” гэснийг “Т+10 хувь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах саналаа тайлбарлаж, үг хэлэв.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь” гэсэн мөрний “Зорилтот түвшин” баганын 2027: “36” гэснийг “32” гэж, 2028: “51” гэснийг “40” гэж,

2029: “71” гэснийг “50” гэж, 2030: “96” гэснийг “65” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Найдалаа: Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Найдалаа: Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь” гэсэн мөрний “Зорилтот түвшин” баганын 2027: “36” гэснийг “32” гэж, 2028: “51” гэснийг “40” гэж, 2029: “71” гэснийг “50” гэж, 2030: “96” гэснийг “65” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Найдалаа: 8.Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

Төслийн **2 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “1.2.1.7” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.2.5” гэж, “Салбар” баганад “71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ” гэж, “Үр дүн” баганад “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, “Арга зам” баганад “Үзлэг, оношилгоо, шинжилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам” гэж; **3 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “1.2.1.7” гэж, “Салбар” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, “Үр дүн” баганад “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүн ам” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+3%, 2027: Т+5%, 2028: Т+8%, 2029: Т+10%, 2030: Т+15%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн яам, Мэдээлэл цуглуулах арга зүй:

Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

Төслийн **2 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.7” гэж, “Салбар” баганад “72212 Гэр бүлийн хөгжил, хамгаалал” гэж, “Үр дүн” баганад “Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Арга зам” баганад “Угийн бичгээ хөтлөх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж; **3 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Монголын хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Угийн бичгээ хөтөлдөг гэр бүл” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+3%, 2027: Т+5%, 2028: Т+8%, 2029: Т+10%, 2030: Т+15%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 12
Бүгд: 18
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 1.2.1.4 дэх дэд заалтад доор дурдсан агуулгатай шалгуур үзүүлэлтүүд нэмэх:

“Шалгуур үзүүлэлт” баганад “Эрүүл мэндийн салбарт зарцуулж буй зардлын ДНБ-нд эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 3.2” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 3.5, 2027: 5, 2028: 5.5, 2029: 6, 2030: 6” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн статистик, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Үндэсний тооцоо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам, Сангийн яам” гэж, мөн

“Шалгуур үзүүлэлт” баганад “Засгийн газрын нийт төсөвт эрүүл мэндийн эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 8.3” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 10, 2027: 11, 2028: 11.5, 2029: 12, 2030: 12” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн статистик, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Үндэсний тооцоо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам, Сангийн яам” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

11.Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.2.4 дэд заалт нэмэх:

Төслийн **2 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.6.7” гэж, “Салбар” баганад “72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Арга зам” баганад “Анхдагч хуулийн төсөл шинээр боловсруулах, батлуулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, **3 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ахмад настны (55-70 хүртэлх хөдөлмөр эрхлэлтийн түвшин)” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: “38.4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 39.0, 2027: 39.6, 2028: 40.2, 2029: 40.8, 2030: 41.4” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 16
Бүгд: 18
11.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Гурав.Тогтоолын төслийн 4 дүгээр хавсралттай холбоотой санал:

Б.Найдалаа: 12.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын “4.1.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 7 дахь дэд заалтын “Төсөвт өртөг /сая төгрөг/” баганын

“468,000.0” гэсний харгалзах мөрний “2026” баганад “-” гэснийг “93,600.0” гэж, “2027” баганад “93,600.0” гэснийг “81,895.0” гэж, “2030” баганад “210,610.0” гэснийг “128,715.0” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр хавсралтын “4.1.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 7 дахь дэд заалтын “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатарт 41” гэснийг “Улаанбаатарт 31” гэж, мөн хавсралтын “4.2.Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-ийн 7 дахь дэд заалтын “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатарт 41” гэснийг “Улаанбаатарт 31” гэж, “2030” баганад “80” гэснийг “100” гэж, “2026” баганад “0” гэснийг “10” гэж, “2027” баганад “0” гэснийг “35” гэж, “2028” баганад “1” гэснийг “60” гэж, “2029” баганад “1” гэснийг “80” гэж, “2030” баганад “1” гэснийг “100” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 35 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “35” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Боловсролын салбарын багш ажилтныг орон сууцжуулах төсөл” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 13
Бүгд: 18
27.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 36 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “36” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Багшийн хөгжлийн үндэсний төвийн барилга /Улаанбаатар хот/” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18
38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 37 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “37” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Боловсролын сургалтын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “ХХААХҮЯ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

17.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 38 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “38” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнсний үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “ХХААХҮЯ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18
38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

“Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн биелэлтэд хяналт тавьж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Найдалаа: “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн биелэлтэд хяналт тавьж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Байнгын хорооны дарга Б.Найдалаа, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Д.Жаргалсайхан, Д.Батбаяр, Б.Заяабал, Х.Жангабыл, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн, Х.Болормаа, Д.Ганмаа, Д.Энхтуяа, Л.Энхнасан, С.Эрдэнэбат, С.Зулпхар, Т.Мөнхсайхан нар ажиллахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяаг дэмжсэнээр тооцож, 66.7 хувиар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа нар байлцав.

“Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Найдалаа: “Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Байнгын хорооны дарга Б.Найдалаа, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Д.Жаргалсайхан, Д.Батбаяр, Б.Заяабал, Х.Жангабыл, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн Х.Болормаа, Д.Ганмаа, Д.Энхтуяа, Л.Энхнасан, С.Эрдэнэбат, С.Зулпхар, Т.Мөнхсайхан нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 10 цаг 18 минут

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Гишүүдийнхээ өглөөний мэндийг эрье.

Байнгын хорооны хуралдааны ирц бүрдээд хурал эхлэхэд бэлэн болсон байна аа. Хурлын ирцийг танилцуулъя. Ирсэн байгаа гишүүд Аюушийн Ариунзаяа,

Амгаланбаатарын Ганбаатар, Сархадын Зулпхар Бадрахын Найдлаа, Доржзовдын Энхтуяа, Жадамбаагийн Баясгалан, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Отгоны Саранчулуун, Мөнхчулууны Энхцэцэг, Жанчивын Галбадрах, Мөнгөнцогийн Ганхөлөг, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Лутаагийн Энхнасан, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд хүрэлцэн ирж, Байнгын хорооны хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Ирц танилцуулж дууслаа.

Өнөөдрийн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэх байгаа.

Нэгдүгээрт, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явна.

Хоёрдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэнэ. Ажлын хэсэг байгуулах тухай.

Ийм 3 асуудал хэлэлцэнэ ээ. Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэгдүгээр асуудал. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ ээ.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Эрүүл мэндийн сайд Чинбүрэн, Боловсролын сайд Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Л.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучууд залуучуудын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат, Төслийн үр дүнд суурилсан төлөвлөлтийн зөвлөх Г.Цэрэнжаргал. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын салбар дундын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжлийн нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чандмань, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Райымбек, Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Отгонцэцэг, Сангийн яамнаас Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Хот байгуулалт барилга, орон

сууцжуулалтын яамнаас Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Инженерийн хэлтсийн дарга Батбаяр, Боловсролын яамнаас Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Должинсүрэн, Дээд мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Нарангэрэл, Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Цогзолмаа, Цахим бодлого, статистик мэдээллийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Түмэнжаргал, СӨБ-ын хэлтсийн дарга Мягмар, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Бадамжав, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал Оюунаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны газрын дарга Алимаа, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Отгонбилиг, Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Рэнцэнханд, Спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Хөрөнгө оруулалтын албаны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Амгаланзаяа, ЭМЯ-наас Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг тор орлон түр орлон гүйцэтгэгч Туяа, бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Оюунсүрэн, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Энхтуяа. Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Галбадрах гишүүнээр тасалъя.

Энхнасан гишүүний микрофоныг нээе.

Л.Энхнасан: Баярлалаа. Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтгая. Эрүүл мэндийн сайдаас ганц 2 юм асуумаар байна. Хүний хөгжлийн бас нэг хамгийн том үзүүлэлт бол эрүүл мэнд. Үүндээ бол нийтийн эрүүл мэнд орж байгаа. Эрүүл мэндийн хүний хөгжлийн үзүүлэлтээр эрүүл зөв амьдрах хэв маягийг дэмжинэ гэсэн нэлээн том зорилт орж үүнд хүн амын биеийн бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ ээ. Хүн амын биеийн бялдрын хөгжлийн түвшнийг 76.2 байгаа. Тэрийг 81 болгоно гэсэн байна. Үүнд нийтийн биеийн тамир, боловсролыг дэмжих, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, спортын сургалт, дасгалжуултын уялд уялдааг сайжруулна гэсэн байна аа. Тэгээд энэ ямар ямар ажлуудыг ер нь хийхээр төлөвлөж байгаа юм бэ?

Хоёрдугаарт аялал жуулчлалын чиглэлээр бас асуумаар байна. Ер нь олон жил зам дагуух нийтийн үйлчилгээний газар байгуулах, үүндээ нөгөө боловсон 0-той болгох гэдэг асуудлыг олон жил л ярьж байна. Бараг ороод хориод жил. Энэ өнгөрсөн жилийн 5 жилийн үндсэн хөтөлбөрт орсон байсан энэ жил л ороогүй байна. Энэ дээр ямар ажил хийгдэж байгаа юм бэ?

Б.Найдалаа: Чинбүрэн сайд хариулна микрофон 3.

Ж.Чинбүрэн: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн ер нь боловсрол нийтийн эрүүл мэнд манай энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах, урт наслах, чанартай урт наслахын гол үндсэн суурь нь. Энэ чиглэл дээр бид бас Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль батлагдсантай холбоотой ирэх 5 жилд илүү Монгол хүнийг эрүүл амьдрах, эрүүл чийрэг Монгол хүн өвчинд баригдсан биш илүү урт насалж чанартай урт наслах боломжийг бүрдүүлэх

ийм том зорилго орж байгаа. Энэ дотроо бол Аялал жуулчлал, спортын яамтай бас хамтран хэрэгжүүлэх нэг том үндсэн ажил бол энэ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлого цогцоороо бас орж байгаа. Ер нь бол энэ хүний чанартай амьдралын индексийн гол үзүүлэлт бол ерөөсөө л энэ бид эрүүл амьдрах ухаан боловсролтой байх нь их чухал юм аа.

Тэгээд би энэ ЭМЯ-аас нэг барьж байгаа том зорилго бол бид муу зуршлаас сайн хэвшил рүү шилжье гэсэн ийм том зорилго тавьж байна. Тэгээд энэ дотор бид илүүдэл жингийн асуудал бол энэ нийтийн биеийн тамиртайгаа шууд хамааралтай холбоотой орчихно. Энэнтэй холбоотой бас илүүдэл жин болон цусан дахь өөхний агууламж энэ нь өөрөө халдварт бус өвчин гол шалтгаан болж байгаа зүрх судасны өвчний гол зүйл байгаа. Тийм учраас энийг нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлд тэр дотроо мэргэжлийн спортын холбоодуудтай хамтарсан том компанит үйл ажиллагаа ирэх 5 жилд явуулж олон нийтийг биеийн тамир спортоор хичээллэдэг байх энэ том үйл ажиллагааг хөгжүүлэх зорилготой энэ төлөвлөгөө явж байна аа.

Б.Найдалаа: Дараагийн хариултыг Даваацэрэн дарга. Микрофон 5 руу суух уу? Микрофон 5-ыг нээе.

Б.Даваацэрэн: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Тэгэхээр 5 жилийн үндсэн чиглэлд аялал жуулчлалын хөгжлийн индексийг дээшлүүлэхтэй холбоотой зорилт туссан, арга хэмжээ туссан. Энэ хүрээнд бид энэ аялал жуулчлалын байгууллагуудын дэд бүтцийн хангамжийг сайжруулах чиглэлээр ажлууд төлөвлөсөн. Засгийн газар энэ аялал жуулчлалын салбарын оролцогчдод хөнгөлөлттэй зээлийг олгож байгаа. Энэ зээлийн нэг шалгуур бол орон нутагт барьж байгуулж байгаа барилга байгууламж, бусад энэ аялал жуулчдыг хүлээж авах байгууламж дээр энэ нолийн асуудлыг бол тусгай шалгуур болгож тавьж байгаа. Өөрөөр хэлбэл орчин үеийн шаардлагад нийцсэн 0-той. 5 номер минут нэмье, гүйцээж хариулъя. Бусад үйлчилгээг хангах ийм бүтээн байгуулалтыг дэмжих ийм бодлого хэрэгжүүлж байгаа.

Тэгэхээр 2026 онд бол улсын төсөв дээр 150 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр суусан. Энэ эх үүсвэрээр дамжуулж саяын хэлээд байгаа нолийн болон бусад үйлчилгээний чанарыг сайжруулахтай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлээд явна гэж ойлгож болно.

Б.Найдалаа: Энхнасан гишүүн тодруулж асуух уу? Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Зүгээр юу эрүүл мэндийн одоо сургуулиуд дээр ер нь эрүүл мэндийн хөтөлбөр орчихсон байгаа шүү дээ. Энэ бас сайшаан сайн зүйл байгаад байгаа. Тэгээд ер нь энэ нийтийн эрүүл мэндийг хөгжүүлэх төсвөө ер нь нөгөө Чинбүрэн сайдаа нөгөө сан байгаа шүү дээ тиймээ? Нийтийн эрүүл мэндийг дэмжих сангаасаа бол гаргах хэрэгтэй шаардлагатай байна. Энийг бас нөгөө өнгөрсөн жилийн төсвийн биелэлтийг гүйцэтгэлийг харахад бол хангалтгүй зарцуулсан байсан. Ялангуяа энэ хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой энэ хөтөлбөрүүдийг дэмжих энэ төсвөөсөө мөнгөө гаргаарай гэж хүсэж байна. Мөн аялал жуулчлалын чиглэлээр тэр нолийн асуудлуудыг бол нэг бодлын инээдэмтэй ч юм шиг. Тэгэхдээ ер нь бол жуулчид ирээд зүүн бүс рүү баруун бүс.

Б.Найдалаа: Нэмж авах юм уу болсон уу? За баярлалаа. Үг хэллээ гэж ойлголоо.

Дараагийн гишүүн Зулпхар гишүүн асуулт асууна.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийнхний өдрийн амгаланг айлтгая.

Зургаан тодорхой асуулт байна. Эхний 2 асуулт Хүний хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас асууя. Ажиллах хүчний оролцооны түвшнийг яаж тооцож байгаа вэ? Хэрхэн нэмэгдэнэ, хэрхэн өөрчлөгдөнө гэж та бүхэн тооцож орж ирж байгаа вэ? Бас эхний асуулт байна.

Хоёр дахь нь энэ цалин хөлсний бодлоготой холбоотой бас ямар зорилт байна? Энэ яах вэ цалин хөлсний бодлогоо бид чинь ДНБ-ий тодорхой хувь руу бас дөхүүлэх ёстой гэсэн ийм зөвлөмжтэй шүү дээ. Тийм ижил түвшний орнуудаас бид чинь 8.5-аас 13.5 хувийн ийм функтээр доогуур байдаг. Тэгэхлээр энэтэй холбоотой бас ямар та бүхэнд зорилт тавьж байна. Энэ биелэх боломж нь хэр байгаа вэ гэдэг ийм асуулт байна. Боловсролын сайдаас мэргэжлийн болон техникийн боловсрол дээр ямар жишээ нь зорилт тавьж байна аа? Ер нь бид дээд боловсролд хамрагдагсдынхаа тоог харьцангуй багасгаад хувийг гэсэн үг шүү дээ. Мэргэжлийн болон техникийн боловсрол дээр нэмэгдүүлье гэдэг ийм зорилт тавьсаар ирсэн. Энэтэй холбоотой бас үр дүнгүүд гарч байх шиг байна.

Тэгэхээр цаашдаа 5 жилийн дотор энэ яаж өөрчлөгдөх вэ? Энэ өөрөө хөдөлмөрийн зах зээл дээр бас ямар нөлөөлөл үзүүлэх ёстой вэ гэдэг дээр та бүхэн ямар тооцоолол хийж байна гэсэн нэг ийм асуулт байна.

Англи хэлний түвшнийг яах вэ? 3 дугаар ангиасаа эхлээд англи хэл үзэж байна. Англи хэлийг их чухал гэж ерөөсөө бид ойлгох ёстой. Монгол хүн бол нэг гадаад хэлгүй бол бид үндсэндээ хөгжлийн хувьд ер нь өөрсдийгөө ховорхон байна л гэж ойлгохоос өөр аргагүй. Энэ үүднээс нь англи хэлийг бол угаасаа хуульчлаад бид оруулчихсан учраас энэтэй холбоотой бэлтгэл хэр хангагдаж байна, ямар үр дүн гарах вэ гэдгийг та бүхэн яаж тооцож байна.

Гурав дахь асуулт. Бас энэ хиймэл оюун ухааны ухааны энэ сургалтыг хөтөлбөрт оруулахтай холбоотой та бүхний бэлтгэл ямар байна? Энийг 5 жилийн дараа бид бас ямар түвшинд хүргэх вэ? Ер нь жил жилд ямар өөрчлөлт хийх вэ бэлтгэл яаж хангагдах вэ гэдэг дээр та бүхэн бас ямар бэлтгэл хангаж байна гэсэн ийм асуулт байна. Эдийн засаг хөгжлийн яамнаас асууя.

Шинжлэх ухаан, инновацын салбарт ер нь ямаршуу өөрчлөлтүүд гарах юм бэ? Бид нэг ДНБ-ий 0.5 хувь хүргэнэ гэсэн зорилт тавьсан. Энийгээ угаасаа хангахгүйгээр яваад байгаа. Гэхдээ энэ удаагийн төсөв дээр бид харьцангуй бас нэг жоохон үр дүнгүүд гаргалаа. Гэхдээ тэр нь угаасаа хангалттай биш. Энэ дан ганц шинжлэх ухааны хүрээлэнгүүд биш. Энэний цаана инновацын асуудал яригдаж байгаа учраас энэ дээр та бүхэн бас ямар зорилт тавьж байна гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Б.Найдалаа: 4 асуулт асуулаа. Тэгээд нөгөө минутаа бас эхний хүн заавал бүгдийг нь ашиглахгүйгээр аль болох товчхон тодорхой гишүүний асуултад хариулаад яваарай гэж хүсье ээ. 1 дүгээр микрофон. Мөнхзул дарга.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Мөнхзул гишүүний асуултад хариулъя.

Ажиллах хүчний оролцооны хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Манай Монгол Улсын хувьд 2024 оны байдлаар дэлхийн дунджаас нэг функтээр илүү байгаа ажиллах хүчний оролцооны түвшин. Харин эрэгтэйчүүдийн ажиллах оролцооны түвшин бол дэлхийн дунджаас бас 2 функтээр ийм доогуур байгаа. Цаашид төлөвлөж байгаа хугацааны эцэст ажиллах хүчний оролцооны түвшин 3.7 функтээр нэмэгдүүлнэ. Энэ дотроо 4.5 функтээр эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшнийг нэмэгдүүлэх ийм зорилт дэвшүүлж байгаа. Үүний гол үндсэн асуудал нь юу вэ гэхээр манай хувьд төрөх насны эмэгтэйчүүд ажиллах хүчинд төрөх насны эмэгтэйчүүдийн хувийн жин өндөр байгаатай холбогдуулаад хүүхдээ асрах, хүүхэд төрүүлэх энэ байгалиас заяасан үүргээ гүйцэтгэхийн тулд эмэгтэйчүүдийн дундах ажилгүйдэл, ажилгүй байх магадлал өндөр байдаг. Мөн түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настныг асрах энэ чиг үүрэг бас байдаг. Ийм учраас ер нь цаашдаа бодлогын хувьд хүн асарч байгаа энэ ажлыг аль болохоор эдийн засгийн албажуулсан байдал руу шилжүүлэх чиглэлээр бодлого баримталж байгаа. Энэ чиглэлээр Халамжийн хуулийг шинэчилнэ.

Цалин хөлсний түвшинд бол үндсэндээ ДНБ-д эзэлж байгаа улсын нийт цалингийн түвшин 45-аас дээш хувь байж байж улс орнуудын хувьд тухайн одоо ажиллагчдын цалингаараа илүү бололцооны түвшинд амьдрах нөхцөл бүрдэнэ гэсэн судалгаа байдаг.

Тэгэхээр цалин нэмэгдүүлэхийн тулд бид бүтээмжийг бас дэвшүүлж байна. Цаашдаа бол хугацааны эцэст дунджаар энэ Монгол хүний дундаж цалин 4 сая орчим төгрөгт хүрнэ гэсэн ийм ерөнхий тооцоолол бид нар өөдрөгөөр төсөөлж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Микрофон 4. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Мэргэжлийн болон техникийн боловсролын тухайд бол бид элсэлтийг нэмэгдүүлэх бодлого барьж байгаа. Энэ жил 21 мянгаар нэмэгдүүлнэ. Түүний зэрэгцээ хос сургалтыг оруулж ирж байгаа. Хосмог тогтолцоог ажиллангаа суралцдаг, суралцангаа ажилладаг энэ тогтолцооны энэ хүрээнд энэ жил элсэлтийг нь 409-ийг 1600 болгож нэмэгдүүлж байгаа. Ер нь яг ийм мэргэжлийн болон техникийн боловсрол дээр ингэж хүчээ анхаарлаа тавих юм бол дээд боловсролын бас элсэлт буурах хандлага гарна гэж харж байгаа. Бид дээд боловсрол дээрээ бол босго оноог дээшлүүлэх, элсэлтийн шалгалтын босго оноог дээшлүүлэх бодлогыг барьж байгаа. Ноднин жилээс 10 оноогоор дээшлүүлсэн ийм бодлогыг барьж байна аа.

Тэгэхээр үнэхээрийн өнөөдрийн бүтээн байгуулалтад хэрэгтэй Монгол Улсын ирээдүйн хөгжилд хэрэгтэй байгалийн ухаанд суурилсан ийм мэргэжлийн чиглэлүүд мөн ахуйн амьдралд үйлчилгээнд суурилсан ийм мэргэжлийн чиглэлүүддээ бид бас түлхүү боловсон хүчнийг бэлдэх.

Б.Найдалаа: Дараагийн хариулт. Гүйцээж хариулах юм байна.

П.Наранбаяр: 4 боломжтой болно оо гэж харж байна. Англи хэлний сургалтын тухайд бол энэ жил 3 дугаар ангиас эхлээд бид нэмэлт хөтөлбөрөөр зааж эхэлсэн. Бүхий л төрийн өмчийн сургуулиудын хүүхдүүд англи хэлний пийрсоны хөтөлбөрөөр хичээллэж байгаа.

Ер нь боловсрол судлалын олон улсын жишгээр бага ангийн гадаад хэлний сургалт 7 хоногт нэг 2-оос 3 цагийн хүрээнд байхад болно гэж үздэг. Бид бол энэ 4-өөс 5 жилийн хугацаанд суурь түвшнийг нь тавиад дунд сургуульд нь дунд түвшинд тавиад, ахлах ангид шилжиж орж ирэхдээ IELTS, PT гэх мэт олон улсын шалгалтад хангалттай суурьтай болсон ийм хүүхдүүдийг бэлдэх ийм боломжтой болно оо гэж харж байгаа. Ер нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын энэ үзүүлэлтүүдэд англи хэлний хичээлийн гүйцэтгэлийн дунджийг жил болгон 15 хувиар нэмэгдүүлэхээр ингэж тусгасан байгаа.

Хиймэл оюун ухааны тухайд бид нар.

Б.Найдалаа: 4 номерын микрофон.

П.Наранбаяр: Хиймэл оюун ухааны тухайд Компьютерын ухаан гэсэн ийм хичээлийг бид бас энэ бага боловсрол дээр бас оруулж ирэхээр төлөвлөж ажиллаж байгаа. Мөн СӨБ дээр компьютерын тухай төсөөлөлтэй болгох ийм бас хөтөлбөрийг боловсруулаад явж байгаа. Тэгэхээр энэ компьютерын ухаан хөтөлбөрийн нэг хэсэг нь бол хиймэл оюун ухаан байна. Хиймэл оюун ухааныг хэрхэн зөв ашиглах, хэрхэн үүнийгээ үндсэн зарчмыг нь ойлгох вэ гэсэн ийм зүйлүүд орж ирнэ. Үүнтэй холбоотойгоор бас Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоол, мөн бусад Боловсролын сайдын сургалтын хөтөлбөр шинэчлэх тухай 25 оны А404 дүгээр тушаалаар тус тус энэ сургалтын үндсэн үзэл баримтлалуудыг оруулж ингэж батлуулсан байгаа.

Ингээд бага боловсролын хөтөлбөр хэрэгжиж эхлэхээрээ энэ хичээл ороод ирнэ. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Микрофон 2. Эдийн засгийн хөгжлийн яам мөн үү. 6 юм байна. Хэн нь хариулах билээ хэлж болно шүү.

Б.Ганбат: Сайдын зөвлөх Ганбат байна. Шинжлэх ухаантай холбоотой зорилтыг үндсэн чиглэлд нэлээн өргөн тавьж өгсөн. Гол нь болохоор энэ шинжлэх ухаан технологийн салбараас улсын хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглалын чиглэлээр гарах үр дүнг нэвтрүүлэх ашиглах талаар зорилтыг оруулсан байгаа. Ингэхдээ ер нь шинжлэх ухаан технологийн үйл ажиллагааг зөвхөн салбарын сайд биш бүх сайдын чиг үүрэгт оруулж өгсөн байгаа. Ялангуяа судалгаа, хөгжүүлэлт, хувийн хэвшил болон салбарын яамтайгаа гадаадтай хамтарсан төсөл хөтөлбөрүүдээс орох санхүүжилтийг нэмэгдүүлэх гарсан үр дүн оюуны өмчийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой зорилтуудыг тавьсан байгаа. Үүнтэй холбоотойгоор бас орон нутаг, нийслэл, орон нутгийн хэмжээнд хийгдэх судалгаа санхүүжилтийг орон нутгаас.

Б.Найдалаа: 6 номер нэг минут.

Б.Ганбат: Судалгааны үр дүнг авч ашиглах, инновацыг нэвтрүүлэх талаар өнөөдөр гарсан байгаа бизнесийн орчныг сайжруулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах гарчихсан байгаа хуулиуд бол ерөөсөө хэрэгжилт хангалтгүй байгаа. Энэ чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог татахтай холбоотой үйл ажиллагаануудыг тусгасан. Ингэснээр улсын хөгжлийн хөгжилд оруулах шинжлэх ухааны үр дүн, мэдлэгийн индексийг нэмэгдүүлэх ийм зорилтуудыг тусгасан байгаа. Арга хэмжээнүүд бүгдээрээ бол жил жилийн хөгжлийн төлөвлөгөөнд салбар салбараасаа тусаад явахаар төлөвлөсөн байгаа.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулж асууна.

С.Зулпхар: Баярлалаа. Наранбаяр сайдаас бас нэг зүйл тодруулчихъя. Энэ нөгөө англи хэлнийхээ сургалтыг зохион байгуулахтай холбоотойгоор багш нараа бэлдэх нэг тийм бас ажил эхэлж байгаа шүү дээ. Багш бэлтгэгдэхгүй бол тэндээс ямар ч байгаад сайн болдоггүй юм л даа. Энэнтэй холбоотой энэ ямар үр дүн хүлээж байгаа вэ гэдэг нэг ийм асуулт байна. Ялангуяа багш нар дээр шүү дээ.

Хоёр дахь нь би Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя. Тэгээд их чухал зорилт тавьсан байна. Бид зорилт тавиад бас тодорхой үр дүн ч гэсэн энэ удаагийн төсөл дээр бас гарлаа л даа. Тэгээд таны саяын хэлснээс бол бид ер нь судалгаа хөгжүүлэлт буюу RNTD нь нэвтрүүлэх юм байна гэж ойлгож байна. Энэ ер нь геологи хайгуул дээр хэр нэвтрэх вэ? Манайх чинь уул уурхайн улс мөртөө геологи хайгуул нь ер нь хийгдээгүй ийм улсуудын тоонд ордог шүү дээ. Энэ дээр бас ямар зорилт байгаа юм?

Б.Найдалаа: Микрофон 4 Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ үнэхээрийн англи хэлний багш нарыг бид энэ бага сургуулиас нь эхлээд англи хэлийг заалгаж эхэлж байгаа учраас нэлээн олон тооны багш хэрэгтэй гэсэн ийм судалгааны дүгнэлт гарчхаад байгаа. Бид багш нарыг богино хугацаанд бэлтгэх шаардлагатай байгаа.

Нэгдүгээрт англи хэлний багш нарыг хөрвүүлж авчрах, 2 дугаарт бас энэ Филиппин гэх мэт орнуудад бас энэ Энэтхэг гэх мэт орнуудад богино хугацаанд англи хэлнийхээ багш нарын чадварыг сайжруулах энэ сургалтын ажлыг эхлүүлэхээр явж байна. Өнөөдөр энэ эхний ээлжид 300 гаран багшийг 1 сарын сургалтад хамруулахаар ингээд ийм ажлуудыг эхлүүлээд явж байна. Тэгээд англи хэлний багш нарт бас тулгамдаад байгаа зүйл нь өөрсдөө нөгөө англи хэлээрээ итгэлтэйгээр ярих ийм бас боломжийг бий болгох нь зүйтэй байна гэдэг ийм зорилгоор бэлтгэгдчихсэн ийм англи хэлний багшийг дахин сургах ийм мөн бага ангийн багш нарыг энэ чиглэлээр бэлдэх ийм зүйлүүд байгаа. Түүний зэрэгцээ маш сайн хөтөлбөр.

Б.Найдалаа: Зулпхар гишүүн тодруулж болсон уу? Тодруулъя Зулпхар гишүүн. Та тодруулаад асуучих даа.

С.Зулпхар: Хэл сурах ч гэсэн амаргүй л байдаг. Гэхдээ зарим хүмүүст амархан байдаг л байх л даа. Орчноосоо олдог байх? Яах вэ гадаадад аваачиж сургах нь их сайн. Тэр угаасаа зөв гэж бодож байна. Тэгж байж хэл нь сайжирна. Нөгөөтээгүүр жишээ нь хиймэл оюун ухаанаар бас хэлнийхээ чадварыг

сайжруулдаг тийм боломжууд гарч л байна шүү дээ. Тухайлбал Премо гээд л. жишээ нь тийм аппликэйшн явж л байна. Тэрүүгээр бол ярианы чадавх сайжруулдаг. Энүүгээр та бүхэн ер нь бодож хийж байгаа зүйл байна уу?

Б.Найдалаа: Микрофон 4.

П.Наранбаяр: Тийм орчин үеийн энэ аппликэйшнүүдийг ашигласан ийм сургалтуудыг мэдээж бид нэвтрүүлж байгаа. Түүний зэрэгцээ энэ GMINI академийг гүүглийн хиймэл оюун ухаан ашигласан багшийн ийм туслахууд ороод ирчихсэн байж байгаа. Энүүгээрээ энийг багш нь өөрөө хэлээ солиод англи хэлээр монгол хэлээр алинаар нь ч авах ийм боломжтой болсон ийм нөхцөл байдалтай байгаа. Тэгээд энэ сургалтад бүрэн нэвтрээд ороод ирчихсэн. Ээлжит хичээлээ бэлдэхэд багшид маш их түлхэц болж байгаа. Ийм бас хиймэл оюун ухаан байгаа. Түүний зэрэгцээ бас үндэсний хиймэл оюун ухааныг хөгжүүлэх чиглэлээр бас Боловсролын сайдын тушаал шийдвэрээр бидний дэмжлэгээр бас үндсэн суурь судалгаанууд явагдаж байгаа. Ялангуяа үгийн сан дээр нь ажилласан ийм туршлага жишээ байж байна. Ер нь бид бас энэ англи хэлний багшийг цааш нь яахад энд сайн хөтөлбөр, сайн сурах бичиг, багшийн сайн гарын авлага бас их чухал байгаад байгаа. Энэ нь хөтөлбөр дотроо бүрэн шингэсэн.

Б.Найдалаа: Баярлалаа. Микрофон 6.

Б.Мөнхтөр: Эдийн засаг, хөгжлийн яам ШУТБГ-ын дарга Мөнхтөр байна. Зулпхар гишүүний асуултад хариулья.

Уул уурхайн салбарыг дэмжихтэй холбоотойгоор бол инженерийн 5 жилийн үндсэн чиглэл геологийн суурь судалгааны ажлуудыг нэлээн өргөн цар хүрээтэй хийж өгсөн байгаа. Мэдээж бид нарын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, цаашлаад дараа дараагийн орд газрууд эдийн засгийн эргэлтэд бэлтгэх ийм хэрэгцээ шаардлага байгаа гэдэг агуулгаараа суурь судалгааны ажлуудаар нэн тэргүүнд агаарын геофизикийн ажлуудыг нэлээн өргөн цар хүрээтэй төлөвлөөд оруулчихсан байгаа.

Хоёрт улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ геохими судалгааны ажлуудыг 200 мянгын штабтайгаар энэ бүрэн бүрхэнэ гэдэг агуулгаар оруулаад өгчихсөн байгаа.

Гуравт мэдээж саяын яригдсан үр дүн дээрээ сууриалаад дараа дараагийн орд газруудыг олж илрүүлэх нөөцийг тогтоох эрэл үнэлгээний шатны ажлуудыг би үндсэндээ суулгаж өгсөн байгаа. Ингэснээр бид нар үндсэндээ суурь.

Б.Найдалаа: Гүйцээгээд хариулчих уу? Нэг минут.

Б.Мөнхтөр: Суурь болон хэрэглээний түвшний судалгаанууд ажлуудыг цогцоор нь төлөвлөж өгсөн гэж хэлж болно. Энэ судалгааны ажлын үр дүнгүүдийг дараа дараагийн бид нэгд уул уурхайн салбарт ашиглах өргөн боломжтой.

Хоёрт дэд бүтэц, хот төлөвлөлт, гео экологийн судалгаа болон гео гамшиг гээд бүх чиглэлийн судалгаанд төлөвлөлтийн ажлууд энэ суурь судалгааны үр дүнгүүдийг ашиглах боломж бүрдэнэ гэж харж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ядуурлыг бууруулах тухайд хамгийн сайн арга хэлбэр бол мэдээж хөдөлмөр эрхлэлт. Ийм ч учраас халамжаас хөдөлмөрт гэдэг бодлогыг бид Зулпхар дэд сайдтай манай баг хамт олон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2020-2022 онд намайг сайдаар ажиллаж байхад хэрэгжүүлж байсан. Тэгээд намайг ажлаа хүлээж авч байхад хүнс тэжээлийн дэмжлэг авч байгаа 250 гаруй мянган иргэн байсан бол 2022 онд ажлаа хүлээлгэн өгч байхад 95 мянга болтлоо буурч байсан. Тэгээд энэ ямар учиртай юм бэ гэхээр 1 дүгээрт бид нар хүнс тэжээлийн дэмжлэг авч байгаа иргэдийн үнэлгээг бол хийсэн. Олон жилээр хамрагдаж байгаа, амьдрал нь харьцангуй гайгүй сайжирсан. Эс үгүй бол малын тооноос хамаарсан орон сууц болон тээврийн хэрэгслийн үнэлгээ зэргийг хийж тодорхой хүмүүсийг хассан. Нөгөө талдаа бол хүнс тэжээлийн дэмжлэг авдаггүй сум, хороо гэдэг ийм уралдаан шахуу ийм бодлогыг хэрэгжүүлээд тэгээд маш олон Засаг дарга нар тухайн өөрийнх нь харьяалах айл өрхүүд дээрээ хүнс тэжээлийн дэмжлэг авч байгаа өрхүүд дээрээ тухайлж анхаарч хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлж хүнс тэжээлийн дэмжлэг авдаггүй болох ийм бодлогыг бол хэрэгжүүлсэн.

Улмаар бид Азийн хөгжлийн банкны цар тахлаас үр нөлөөг нь бууруулах хамгаалах энэ төслийн 2 дугаар үе шатын төслийг бол градуишн аппрөүч буюу төгсөлтийн аргачлалаар Улаанбаатар хотын 3 дүүргийн буюу СХД, ЧД болон БЗД 3 дүүргийг сонгоод 1250 айл өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонгож тухайн айл өрх дээр нь хөгжлийн үнэлгээ хийгээд хөтөлбөр гаргаад 2 жилийн хугацаанд 20 айл тутамд нэг көүч буюу нэг хяналт тавьдаг зөвлөдөг хүнийг тусгайлж гарган нэг айл өрх дээр 600 долларын хөрөнгө оруулалт хийж тухайн айл өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд нь нийцсэн ямар бизнес хөгжүүлж болох вэ? Буузны байна уу эс үгүй бол үсчин байна уу, эс үгүй бол юу гэдэг юм хэрчсэн гурил байна уу, хүлэмж байна уу гэдгээсээ тухайн айл бүрийнх нь боломж дээр нь суурилсан төлөвлөгөөг гаргаж ингээд 2 жилийн хугацаанд ажилласан байх учиртай. Тэгээд би яагаад учиртай гэж байна вэ гэхээр намайг сайдаас буухад яг энэ төсөл дөнгөж эхэлж байсан.

Тэгэхээр би хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ төслийн үр дүнгийн талаар асуугаад цаашид хэрхэн яаж үүнийгээ төрийн бодлого болгох ажил хийгдэж байгаа вэ? Энэ хамгийн чухал нь бол ердөөсөө л халамжаас хөдөлмөрт гэдэг асуудал бол өнөөдөр яг халамж хүртэж байгаа ядуурлын түвшинд байгаа айл өрхүүдийг.

Б.Найдалаа: Баярлалаа хариултыг нэг номерын микрофон өгнө.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул гишүүний асуултад хариульъя. Ариунзаяа гишүүний хэлсэн төсөл амжилттай хэрэгжиж дууссан. Тэгэхээр 1259 өрх санамсаргүй түүврийн аргаар сонгогдоод дандаа хүнсний талон авдаг байсан өрхүүд. Эдгээр өрхүүд 2 жил хагасын хугацаанд 80 хувь нь ядуурлаас гарсан. Ядуурлаас гарсан үндсэн одоо шалтгаан буюу аргачлал нь юундаа байсан бэ гэхээр шууд бэлэн мөнгөний тэтгэмж амлаагүй. Гол асуудал нь бол тухайн өрхөд үнэлгээ хийгээд өрхийн гишүүдийн хүсэл зорилгод үндэслээд хөдөлмөр эрхлэх үү, аль эсвэл өөрийн гэсэн жижиг бичил бизнес эрхлэх үү аль эсвэл өөр газар ажилд орох уу гэдэг байдлаар өрхийн төлөвлөгөө гаргаад тухайн өрхүүдийн өрхийн гишүүдийг хөдөлмөрлөх дадал эзэмшүүлсэн, мэргэжлийн сургалтад хамруулсан. Улмаар 11 төрлийн тоног төхөөрөмжийг санал болгосон.

Ингээд бизнесээ эрхлээд эхлүүлээд явж байгаа хүмүүсийн хувьд маркетингийн болон борлуулалтын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх кочууд ажиллуулсан гэх мэт үндсэндээ нэг 18-аас 24 сарын арга хэмжээг өрх тус бүр дээр авч ажилласнаар нийт өрхийн 80 хувь нь ядуурлаас гарч чадсан.

Тэгэхээр цаашдаа бол монгол өрхүүдийн хувьд тодорхой хэмжээний ийм цогц дараатай арга хэмжээний үр дүнд ядуурлаас богино хугацаанд гарах ийм магадлал маш өндөр байгаа олон улсын хандлагаар градиушн аппроуч буюу энэ төгсгөх буюу ядуурлаа төгсгөх гэж байгаа юм. Тэгэхээр ядуурлаас төгсгөх энэ аргачлал хамгийн ядуу буюу туйлын ядуу хүмүүст илүү их зохистой байдаг. Манай Монгол дунджаар олон улсын жишгээр 36 сарын хугацаанд өрхүүд ядуурлаас гардаг хамгийн эртдээ. Манай Монгол өрхүүдийн хувьд бол нэг 18 сарын хугацаанд бүрэн ядуурлаас гарах боломжтой байгаад байгаа юм аа.

Хамгийн эмзэг өрхүүдийн хувьд бол зан үйлийн доголдолтой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хөдөлмөр эрхлэх чадваргүй энэ хүмүүсийн хувьд бол ядуурлаас гарахад хүндрэлтэй байгаа. бусад өрхүүдийн хувьд харьцангуй боломжтой байгаа. Тэгэхээр энэ туршилтын хөтөлбөрийн арга зүйг хүнс тэжээлийн дэмжлэг олгох журамдаа бол тусгачихсан. Одоо Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад мөн тодорхой хэмжээнд тусгаад явж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүн тодруулж асууна.

А.Ариунзаяа: Тэгэхээр 1259 айл өрхөд хэрэгжүүлсэн энэхүү төсөл маань 80-аас дээш хувь 80 хувийн амжилттай байна гэдэг чинь маш сайн аргачлал байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр яг үүнийг бол манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эдийн засаг, хөгжлийн яам маш сайн хэрэгжүүлэх хэрэгтэй. Ер нь бол ядуурлаас гаргаж байгаа энэ арга нь бид нар хаа нэгтээгээс зохиочихсон юм биш. Энэ Хятдад хүртэл өөрөө яг энэ төгсөлтийн аргачлалаар айл өрхүүдтэйгээ ажилладаг. Тэгээд магадгүй манай улсын хувьд бизнес нь харьцангуй гайгүй сайн хөлжөөд явах боломжтой байгаа юм бол төсөв хөрөнгө бага байгаа бол анхны хөрөнгө оруулалтаа буюу 600 долларын энэ хөрөнгө оруулалтыг хүүгүй зээл маягаар аваад бизнесээс нь буцаан төвлөрүүлэх эргээд энэ амжилтын гинжин хэлхээнд оруулах энэ боломж байгаа эсэхийг та хэд маань бас судлаарай.

Ер нь бол Монголын төр иргэддээ маш их.

Б.Найдалаа: Нэг минут нэмж авна. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Монголын төр иргэддээ чиглэсэн маш их мөнгөний бодлогыг бол хэрэгжүүлдэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар хүртэл бид нар сургалтыг ч явуулдаг. Буцалтгүй тусламжийг ч өгдөг, зээлийг ч өгдөг. Тэгэхээр энэ болгоныг уг нь хооронд нь уялдуулаад жоохон зохион байгуулалт менежменттэй явчих юм бол илүү үр дүнтэй байх ийм боломжтой. Тэгэхгүй бол одоо нэг гараараа халамж өгөөд байдаг, нөгөө гараараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа сургалтууд болон одоо жижиг зээлүүдийг өгөөд байдаг. Гэтэл хоорондоо уялдахгүй болохлоор хэн мэдээлэлд илүү ойрхон байгаад байна вэ тэр нь л энэ жижиг зээл тусламжуудыг авчхаад байдаг, хөлжөөд байдаг. Гэтэл нөгөө талдаа яг ядуурал маань ердөөсөө огт өөрчлөгдөхгүй хэвээрээ байгаад байгаа нь бол бас манай асуудал мөнөөс мөн

юм аа. Тэгээд энэхүү хөтөлбөрийг та бүхэн маань бас илүү сайжруулж сайжруулж төрийн бодлого болгож хэрэгжүүлээрэй гэж хүсмээр байна аа.

Халамжаас хөдөлмөрт гэдэг бол ердөөсөө л энэ агуулга. Тэгээд манай яам бол энийг маш сайн хийж байгаа үүнийгээ бас сайн цаашид хэрэгжүүлээрэй гэж хүсмээр байна аа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа үг хэллээ. Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Нэгдүгээрт, энэ 5 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жирийн иргэд ойлгоход хялбаршуулах хэрэгтэй. Бид нар одоо ингээд нэг мөрөөдлийн жагсаалт тавиад иргэд байтугай зарим эдийн засагч нар хүмүүс ч гэсэн ойлгогдохооргүй янз янзын тоо тавиад ийм зүйлүүд бас ингээд харагдаад байна. Ямар ч байсан бол ажилласны хувьд нэлээн цэгцлэх гэж хэлбэрт оруулах гэж оролдсон нь маш сайн. Гэхдээ зарим салбарууд нь яаманд нь өгдөг юм уу, яадаг юм, энэ зарим тоог ерөөсөө ойлгохгүй байгаад байна. Би нэг хэд хэдэн тоо харахыг хүссэн юм. Ирэх 5 жилд ер нь манай иргэдийн бодит цалин хөлс орлого яаж өсөх юм. ДНБ-д эзлэх цалин хөлс яаж өсөх юм. Жилд хэдэн хувиар өсөх юм. Инфляцын түвшинтэй уялдуулан гээд л тавьдаг. Зөвхөн инфляцаа хаах хэмжээний нэмэгдэл гэдэг бол цалин хөлсийг огт өсгөхгүй, бодит цалин хөлсийг огт өсгөхгүй гэсэн үг. Одоо ийм юмыг л иргэд хүлээж байгаа байхгүй юу. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг яаж өсгөх юм. Ахмадын доод тэтгэврийг яаж өсгөх юм гээд яг ийм тодорхой бодитой тоонууд байна уу. Би ерөөсөө хайгаад олж чадсангүй.

Зээлийн хүү хэдэн хувиар буурах юм? Мөн тэр орлогод нийцсэн орон сууц гэж байгаа иргэдийн тоог яг тодорхой тавьсан байна. Гэхдээ тэр орлогод нийцсэн орон сууц чинь метр квадратын үнэ нь ямар үнэтэй байх юм. Аль руу ойртуулах юм гэдэг асуудал байна. Мөн дээрээс нь зарим улс орнуудад иргэдийн энэ төрийн хийж хэрэгжүүлж байгаа, нийгэм эдийн засгийн байдлыг иргэдийн аз жаргалын индекс гэдэг зүйлийг гаргадаг болчихсон шүү дээ. Тэгээд ийм зүйлийг гаргачхаж болохгүй байгаа юм уу? Энэ чинь ерөөсөө бүх зүйлийн зангилаа нэг л үзүүлэлт байхгүй юу. Тэгээд тэр зүйлдээ бүх зүйл нь зангидагддаг. Мөн дээрээс нь дундаж давхаргын тоог нэмэгдүүлнэ гэж байгаа. Эндээ хүргэхдээ 20 хувиар нэмэгдүүлнэ гэсэн байна. Мөн нийгмийн түншлэлийг сайжруулна гэсэн чинь шүүхээр шийдэгдэж байгаа хөдөлмөрийн маргааны тоог бууруулна гээд тавьчихсан. Нийгмийн түншлэлийн 3 талт хэлэлцээрийг сайжруулна гэж байгаа бол тэр чинь бүх хамтын гэрээ хэлэлцээрүүдийн тоог нэмэгдүүлэх, тэрнийх нь хэрэгжилтийн хувийг тэдээс тэдэд хүргэнэ гэж байх ёстой байхгүй юу. Тэгээд ганцхан шүүхийн маргааны асуудлыг байхгүй болгочихвол 3 талт механизм маш сайн ажиллаж байгаа боловч үнэлэх нь л дээ. Тэгээд ийм нөгөө хөнгөн байдлаар яаж болохгүй. Тийм учраас энэ энийгээ тайлбарлаж өгнө үү гэдгийг хэлмээр байна.

Ахмадын туслах үйлчилгээг сайжруулна гэдэг бол маш сайн шинэ үзүүлэлт орж ирсэн байна.

Дээрээс нь нэг зүйл байгаа юм. Тусгай хамгаалалтын газрын хамрагдалтыг нэмэгдүүлнэ гэсэн байж байгаа. Гэтэл яг ний нуугүй хэлэхэд би сая энэ зун Хөвсгөл аймагт очиход тусгай хамгаалалтын газрын хамрагдалтыг нэмэгдүүлэхээр тэнд амьдарч байгаа хүмүүс мал маллах, байгаль орчиндоо дасаж зогсож амьдрахад ямар ч боломж байхгүй болчихсон. Малаа бэлчээж болохгүй. Тэнд юу хийж байна

вэ гэхээр ямар ч ажил хийх боломжгүй учраас архи л уудаг иймэрхүү байдал руу орж байгаа байхгүй юу. Нэмэлт нэг минутаа авчихъя дарга аа.

Минут нэмж өгье Эрдэнэбат гишүүнд.

С.Эрдэнэбат: Тийм учраас тусгай хамгаалалтын газрын тоог нэмж байгаа нь сайн. Гэхдээ тэнд чинь тансаг амралтын газрууд эс үгүй бол хааяа очиж нэг ан агнадаг нэг хэдэн хүмүүст зориулсан юм уу тийм л зүйл болчихоод байна шүү дээ. Тэнд хэрэгжиж байгаа тэр тайгын иргэд, тэнд амьдарч байгаа ард ард иргэдийн амьдрах орчныг улам хязгаарлаад тэнд олигтой хүн малаа өсгөөд бие дааж ажил хөдөлмөр эрхлэх ямар ч боломж байхгүй болгож байгаа юм. Тэгэхээр ийм нөгөө талынх нь эффект сөрөг үзүүлэлтийг харахгүйгээр зүгээр тусгай хамгаалалтын газрын талбайг л нэмээд байвал сайхан болчихно гэдэг юм чинь хэт өрөөсгөл шүү. Амьдралаас тасархай. Ширээн дээр төлөвлөж байгаа төлөвлөгөө чинь ард иргэдийнхээ бодит амьдралд очиж үзэхгүй.

Тийм учраас тэр тусгай хамгаалалттай газрын хэмжээг нэмэгдүүлнэ гэдгээ тэр тайгын иргэд, тэр тусгай хамгаалалттай газрын нутаг орны иргэдээс асуусан уу гэдэг ийм зүйлийг бас асуумаар байна. Асуултаа асуучхаад дараа нь тодруулж хэлье дээ.

Б.Найдалаа: Хариултыг микрофон нэгээс эхлэх үү? Микрофон 1.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул гишүүний асуултад хариулъя. Энэ удаа төлөвлөлтийн нөгөө бодлогын баримт бичгийнхээ загварыг нэлээд өөрчлөөд оруулж ирсэн. Энэ хэд хэдэн үр дүн байгаад байгаа юм. Салбарын үр дүн, салбарын үр дүн гэхээрээ жишээлбэл дундаж цалин хөлсний тухай зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар төдийгүй тэгээд эрүүл мэнд боловсрол гээд бүх салбаруудын хүрээнд хүрэх үр дүнг хэлээд байгаа юм. Үүний цаана яг тэр салбарын үр дүнд хүрэхийн тулд төсвийн ерөнхийлөн захирагч бүр тодорхой төсвийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа юм. Тухайлбал хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр. Тэгэхээр бид нар нийгмийн түншлэлийг сайжруулахын тулд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагч маань хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Энэ хөтөлбөрийнхөө хүрээнд жилдээ 100-аас 120 тэрбум зарцуулна. Энэ хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүнгийн хувьд нөгөө шалгуур үзүүлэлтүүдээ бид нар хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна гээд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийнхөө нэг үр дүн болгоод оруулчхаж байгаа юм. Тэгээд энэ хөтөлбөрийн үр дүнд хүрсэн эсэхээ шалгахын тулд шүүхээр шийдвэрлүүлсэн хөдөлмөрийн маргаан зөвхөн манай салбарын хувьд. Ингээд дээшээ нэгтгэгдсээр яваад үндэсний үр дүн дээрээ нийгмийн түншлэлийн асуудал хангагдана гэсэн энэ бүх ТЭЗҮ-үүдийн нийлбэрээр хангагдана гэсэн энэ загвараар Эдийн засгийн хөгжлийн яамнаас бас оруулж ирсэн гэж ойлгож байгаа байгаа. Тэгээд шүүхийн хөдөлмөрийн хүрээнд гарч байгаа маргаан буурна гэдэг маань үндсэндээ өөрөөр хэлбэл бас анхан шатын нэгжээс авхуулаад нийгмийн түншлэлийн харилцааг сайжруулах үр дүн маань макро түвшиндээ нэгтгэгдэнэ гэж үзээд байгаа.

Дундаж цалин хөлсний хувьд мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих манайх өрөөсөө төсвийн 7-оос 8 хөтөлбөр л хэрэгжүүлж байгаа. Тэр хөтөлбөрүүд дээрээ үр

дүн тавьчихаад яваад байгаа юм. Яг шууд макро эдийн засгийн үзүүлэлт бол хөтөлбөрийн үр дүн болж орж ирэхгүйгээр болчихоод байгаа. Тийм учраас ажиллагчдын цагийн дундаж цалин хөлсийг өсөхөөр ингэж төсөвлөсөн. Нийт ДНБ-д эзлэх цалин хөлсний хувийн жинг үндэсний үр дүн тал руугаа л оруулах нь зүйтэй байх гэсэн саналтай байна. Энэ асуултуудад хариуллаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Индекс тооцож болохгүй юу гэсэн.

Л.Мөнхзул: Индекс тооцож болно. Тэгэхдээ энэ нөгөө төсвийн ерөнхийлөн захирагч тодорхой хэмжээний мөнгө зарцуулж байгаа. Тэр мөнгө маань төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөтөлбөрөөр зарцуулдаг, нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүүхдийн хөгжил хамгаалал, гэр бүлийн хөгжлийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх мэт.

Тэгэхээр энэ зарцуулж байгаа тухайн жилийнхээ мөнгөндөө тухайн тухайн ондоо ямар үр дүнд хүрэх вэ гэдгээрээ төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд илүү нарийвчлаад явчхаж байгаа учраас яг төсвийн захирагчтайгаа холбоотой үзүүлэлтийнхээ үр дүнг л энд оруулчихаад байгаа юм. Хойд талын хэсэгт нь илүү макро үзүүлэлтүүд нь орсон гэж ойлгож байгаа. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яам бас илүү тайлбар хэлэх байх.

Б.Найдалаа: Дараагийн хариулт 2 номер. Эдийн засаг, хөгжлийн яам.

Х.Сүрэнхорол: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу 5 жилийн үндсэн чиглэлийг дээрээс доош буюу өөрөөр хэлэх юм бол Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн нөгөө талаасаа одоо доороос дээш, дээрээс доош буюу өөрөөр хэлэх юм бол доороос дээш буюу өөрөөр хэлэх юм бол төсвийн ерөнхийлөн захирагчтай холбогдох үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж оруулж ирсэн байгаа.

5 жилийн үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 2.1.3 дахь хэсэгт бүтээмж гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоог сайжруулснаар ажиллагчдын цагийн дундаж цалин 2024 онд 9.2 мянган төгрөг байгааг 2030 онд 17.4 мянган төгрөг болгож нэмэгдүүлэхээр холбогдох үр дүн, зорилтуудыг шалгуур үзүүлэлтээ өөрөөр хэлэх юм бол хүрэх түвшинтэй нь тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж орж ирсэн. Энэ хүрээндээ бол хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлнэ гэсэн үр дүнг тодорхойлж орж ирж байгаа.

Б.Найдалаа: Нэг минут нэмж өгье. Та нэрээ хэлээрэй. Тэмдэглэлд үлдэж байгаа учраас. Тэгээд тусгай хамгаалалттай газартай холбоотой хариултыг та өгөх нь ээ.

Х.Сүрэнхорол: ТХГН-ийн менежментийг сайжруулахтай холбоотой үр дүнгүүдийг бас 5 жилийн үндсэн чиглэлд тусгаж орж ирсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай, байгаль орчны яамтай яг үр дүнгүүд дээр нь бас тодорхойлох ажлууд хийгдээд явсан. Энэ дээр болохоор 5 жилийн үндсэн чиглэл дээр тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулж, үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 6.1 дэх хэсэг дээр оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлж улсын ТХГН-ийн эзлэх хувийг үндсэн чиглэлийн 3 дугаар хавсралтын 6.1 дэх хэсэгт өөрөөр хэлэх юм бол 2024 онд 20.8 хувь байгаад байгаа. 2024 оны тоогоор суурь дүнгээ авсан. Тэгэхээр 2030 онд 30 хувь болгож өсгөнө өө гэдэг үзүүлэлтийг тусгаж

орж ирсэн байгаад байгаа. мөн усны эх үүсвэр бүхий газар нутгийн эзлэх хувийг 49.9 хувиас 60 хувь хүртэл нэмэгдүүлнэ ээ гэдэг үр дүнгүүдийг тусгаад өөрөөр хэлэх юм бол хүрэх түвшнүүдийг нь 2 мянга.

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүн тодруулчихаад тэгээд хариултаа авъя. Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Би тэгэхээр наад нэг тусгай хамгаалалттай газрын тоог нэмэх чинь ер нь яг ямар эдийн засгийн үзүүлэлттэй юм бэ гэдгийг л хэлэх гээд байна л даа. Энийг нэмээд байхаар нөгөө талд нь иргэдийн бодит ажил амьдрал унаад байна. Нөгөө талд нь тэр тусгай хамгаалалттай чинь газар нутаг ойг хорхой шавжид идүүлээд дуусах гээд байдаг. Тийм асуудлууд их байгаа юм. Тэгэхээр энэ тал дээрээ бодоорой л гэж хэлж байгаа юм.

Дээрээс нь өмчийн эрхийн баталгааг сайжруулах гэхээр өрхийн бодит орлогыг нэмэгдүүлнэ гээд үзүүлэлт байна. 11 хувиас 5 хувь бууруулна гээд тавьчихаж. Тэгээд өрхийн бодит орлогыг 11 хувиас 5 хувь бууруулъя гэж бодож байгаа юм уу. Энэ 4.1.4 дээр. Мөн тэр ДНБ-д эзлэх цалингийн доод хэмжээг 45 хувь байлгахад олон улсын зохистой харьцаа гэж байгааг бид нар тийшээ хэдэн жил хүргэх юм бэ? Энийг л тодорхой тавиач гэж байгаа юм.

Дээрээс нь төсвийн урсгал зардлыг бууруулна. 22 хувь болгоно гэххэж байгаа юм. Тэгээд хэрвээ ийм төсвийн урсгал зардлыг бууруулна гэх юм бол наад цалин хөлсийг чинь өсгөх боломж бололцоог нөгөө талдаа хумьчихаж байгаа байхгүй юу. Тэгээд хоорондоо ийм зөрчилдөөнтэй ийм асуудал чинь эргээд асуудал болохгүй юу.

Б.Найдалаа: Хариулт 2 номер.

Б.Сүрэнхорол: Эдийн засгийн хөгжлийн яам Сүрэнхорол үр дүнг өөрөөр хэлэх юм үр дүнгийн үзүүлэлт бодитой хэсгийг бас ажлын хэсэг дээр давхар ажлын хэсгийн гишүүдийн хүрээнд бас давхар ярилцах боломжтой. Яах вэ Эдийн засаг хөгжлийн яамнаас бол өрхийн орлогыг нэмэгдүүлэхтэй холбоотой ядуурлаас урьдчилан сэргийлэх, дээрээс нь өмчийн эрхийг баталгаажуулахтай холбоотой холбогдох ажлууд хийгдээд явж байгаа.

Тэгэхээр энэ агуулгын үр дүнгүүд бол бас 5 жил дээр тусгачихсан байгаа. Өөрөөр хэлэх юм нөгөө эдийн засгийн эрх чөлөөг хангах өмчлөх эрхийг баталгаажуулахтай холбоотой үр дүнгүүд орж ирж байгаа. 5 жилийн үндсэн чиглэл дээр холбогдох үр дүнгээ тусгасантай холбогдуулаад жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүд дээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг нарийвчлаад тусгаад явна. 11 хувийг 5 хувь болгохтой холбогдуулаад Энх-Амгалан дарга бас хариулт өгье.

Б.Найдалаа: Микрофон нэг.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам. Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Би өмнөх асуулт дээр нь гарч байсан тэр инфляц зээлийн хүүтэй хэсгээс эхлээд хариулъя. Зээлийн хүүг буурах яг үндсэн шалтгаан нь инфляц өөрөө буурах л асуудал байгаа юм. 5 жил дээр бол инфляцыг үр дүнг нь хэмжихдээ салгаж оруулсан байгаа. Эрэлтийн гаралтай инфляц. Энийг Монгол банк хариуцна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц, ялангуяа тэр дотроо хүнсний инфляц бол Засгийн

газар хариуцна. Импортын инфляц дээр бол тээвэр логистиктой холбоотой аливаа үнийн өсөлт гаргахгүй гэдэг асуудал байгаа. Энийг бас салбарын яам нь хариуцаад явна. Ерөнхий импортын инфляц дээр экспортыг нэ нэмэгдүүлэх тэгснээрээ валютын ханшийг тогтвортой байлгах асуудал байгаа. Энэ хэсгийг бол Эдийн засаг хөгжлийн яам хариуцаад явна гээд үр дүнгийн үзүүлэлтүүдээ ингэж гаргасан байгаа. Өрхийн орлогын тухайд бол төсөв талаас төрийн албан хаагчийн цалин болон.

Б.Найдалаа: Гүйцээж хариулах уу? Нэг номер.

Л.Энх-Амгалан: Төрийн албан хаагчийн цалин болон тэтгэврийг инфляцтай уялдуулаад нэмэгдүүлээд явна гэсэн бодлого баримталж байгаа. Энэ нь холбогдох баримт бичиг хуульдаа ч суусан байдаг. Энэ нь бол өрхүүдийн худалдан авах чадварыг муутгахгүй байх хэмжээний түвшинд нэмэгдүүлнэ гэсэн бодлоготой. Энэнээс цаашаа нэмэгдэх асуудал бол бүтээмжтэйгээ уялдаад илүү нэмэгдээд явахад хязгаарлах асуудал байхгүй. Дор хаяж нэмэгдэх хувийг л харуулсан байгаа. энэнтэйгээ уялдаад цаашаагаа явахаар өрхийн орлого бол мөн адилхан инфляцтай уялдаад дор хаяж 5 хувиараа нэмэгдээд явах ийм зорилтыг л дэвшүүлсэн.

Цаашаа бас нэмэгдээд явахад хязгаарлах зүйл байхгүй гэдгийг нь энд хэлбэ. Төсвийн урсгал зардал 22 хувь дээр хязгаарласан тохиолдолд цалин нэмж чадах уу гэдэг асуудал байгаа юм. Энэ ковидын өмнө өөрөө урсгал зардал өөрөө 21, 22 хувьтай л байсан асуудал. Сая ковидын үеэр нэлээд олон халамж тэтгэмжийн зардлууд нэмэгдээд дагаад бас өөр зардлууд ч нэмэгдээд бүүр 29, 30 хувь руу дөхсөн асуудал байгаа. Энийг яг макро.

Б.Найдалаа: Энх-Амгалан дарга тэр нөгөө инфляц гэдэг дээр хувааж хариуцна гээд юу хэлчхэв энэ чинь. Төв банкны тухай хууль дээр угаасаа Монголбанк хариуцдаг биз дээ. Засаг нийлүүлэлтийг нь эрэлтийг нь гэсэн үү тэгээд? Энийг би бас сайн ойлгосонгүй. Гэхдээ та дараа тодруулаад дараагийн асуулт дээр ч юм уу хариулчхаарай. Тэр Эрдэнэбат гишүүний асуугаад байгаа тэр бас тусгай хамгаалалттай газрын асуудал. Энэ чинь одоо яг 5 жилийн асуудал биш. Аль 1990-ээд онд Монгол Улс нэг амлалт өгчихсөн асуудал санагдаад байх юм.

Тэгэхээр ингээд нэлээн урт хугацаанд явж байгаа бодлого. Тэрийг бас тодорхой хариулчихвал Эдийн засаг, хөгжлийн яамнаас их зүгээр байгаад байгаа. Уг нь зүгээр энэ сая тусгачихсан биш угаасаа удаан хугацаанд явж байгаа бодлого гэдгээ. Саранчулуун гишүүнийг асуулт асуух гишүүний тоонд нэмье. Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Байнгын хорооны дарга, гишүүд ажлын ажлын хэсгийн гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Өнөөдөр бид маш чухал асуудал хэлэлцэж байна аа. Бид нар ерөөсөө энэ төлөвлөлтийг 5 жилээр төлөвлөлтөө маш сайн хийх хэрэгтэй. Энэ дээрээсээ үндэслээд жилийнхээ ажлын төлөвлөлтүүдийг маш сайн хийгээд явах юм бол бид нарын энэ макро түвшинд ч яриад байгаа салбарын түвшинд ч яриад байгаа асуудлууд бүрэн эрх тодорхой болоод хаа хаанаа их хялбар явна аа. Бид Их Хуралд орж ирээд нэг жил боллоо. Тэгээд энд бас нэг ойлгомжгүй байдлууд байгаад байсан. Энэ төлөвлөлтүүдийг бид нар бас сайн харж мэдээллийг сайн авч чадаагүй байсан. Одоо шинэ төлөвлөлт орж ирж байгаад их олзуурхаж байна. Ингээд хэд хэдэн асуулт байгаа бас. Тэгээд хэмжиж чадахгүй бол бид нар төлөвлөж чадахгүй, төлөвлөж чадахгүй бол хэрэгжүүлж чадахгүй ээ.

Тэгэхээр одоо бид нар хэмжих зүйлийнхээ л тэр шалгуур үзүүлэлтүүдийг л маш сайн гаргах гээд байна. Энийгээ их бодитой хэрэгжихээр үнэн бодит одоогийн яг бодит байдлаа эгцэлж харсан байдлаар бид нар гаргах ёстой. Тэр нь тэгээд их ойлгомжтой, ийм тодорхой байх ёстой байна аа. 2026, 2027 оны хөгжлийн төлөвлөгөөг бид нар энэ 5 жилийн төлөвлөгөөг хийснээр их тодорхой болно. Жишээлбэл 2026 онд бид нар хөгжлийн төлөвлөгөөнд хэд хэдэн асуудал туссан байсан. Жишээлбэл сургуулийн хүртээмжийн тал дээр 45 сургууль, 45 цэцэрлэг шинээр барина гээд хөгжлийн төлөвлөгөөнд туссан мөртөө улсын төсөвт ердөө 3 сургууль, 2 цэцэрлэг орж ирж байгаа юм. Тэгээд энэ ямар учиртай хаанаа ингээд хөгжлийн төлөвлөгөө гаргаж байгаа хэрэг байгаа юм уу гэдэг юм байгаа юм. Тэгэхээр бид нар хойшид зарчим барих ёстой. Хөгжлийн төлөвлөгөөнд ороогүй бол тэр зүйлийг одоо төсөвт тусгахгүй гэдэг энэ зарчмаа барих хэрэгтэй. Одоо шинээр ажлын хэсгүүд бол яг энэтэй холбоотой байгуулагдаж байна. Тэгээд би ажлын хэсэгт орж байгаа. Тэр KPI-ууд ялангуяа боловсролын салбарынхаа тэр шалгуур үзүүлэлтүүдийг гаргахад нэлээн ажиллана гэж бодож байна.

Тэгээд бид нар энд ингээд нэг зарчим сайн барих ёстой л доо. Эхлээд салбарынхаа асуудлыг сайн эрэмбэлье. Боловсролын салбарт одоо энэ ямар ямар эрэмбүүдийг хийж байна гэдгийг би Наранбаяр сайдаас бас асууя.

Тэгээд бас сайн төлөвлөлтүүд суурь түвшнүүдийг бодитой гаргая. Би зарчмын зөрүүтэй 5 санал гаргасан байгаа. Тэгээд энэ дотор суурь түвшин нь ямар ч тооцоогүйгээр бодит байдалтай нийцэхгүй ийм худлаа тоонууд бас явсан. Хүрэх үр дүн зорилтот түвшнээ бас бид нар тодорхой тавих ёстой. Энийг бас л судалгаан дээр хэрэг хийх ёстой. Тэгж байж хэрэгжих ийм боломжтой болно. Тэгээд эдгээр асуудлаа бид нар сургуулийн хүртээмж, багшийн хэрэгцээ, хөрөнгө оруулалт, барилгын ажлын явцтай холбогдуулаад 5 зарчмын зөрүүтэй санал тавьсан. Тэрэн дээрээ би их тодруулаад асуугаад явна.

Б.Найдалаа: Хариултыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас Наранбаяр сайдаас эхэлнэ. 4 номер.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээрээ үнэхээрийн бас энэ сургуулийн хүртээмж, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр манай энэ Байнгын хорооны гишүүд бас их санаачилгатай ажиллаж бидэнтэй гар нийлж байгаад бас их баяртай байна. Тэгэхээрээ энэ энэ 26 онд бол бид нийтдээ улсын болон АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр нийт 45 сургууль цэцэрлэгийн барилгыг эхлүүлэхээр ингэж төлөвлөсөн байгаа. Үүнээс 32 нь Азийн хөгжлийн банк, 13 нь улсын төсөв дээр байж байгаа. Тэгэхээрээ 2026 онд улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт хангагдсан ийм хэмжээнд байна. 95 нь цэцэрлэгийн хувьд бол 9 нь ADB, 10 нь улсын төсөв, нийт 19 нь энэ жил шинээр эхлэхээр ингэж байж байгаа.

Тэгэхээр энэ тоонуудаа бас тантай харгуулж харъя. Тэгэхээрээ бид бас энэ 45 сургууль, цэцэрлэгийн барилгыг энэ жил эхлүүлэхээр ингэж тавьсан байгаа. Түүний зэрэгцээ нийслэл болон орон нутгийн төсвүүд ярилцаж яригдаж эхэлнэ. Энэ дээр бас нэмэлтээр жишээлбэл нийслэл гэхэд 24 байршил дээр газар чөлөөлчихсөн. Энэ дээрээ ингээд сургууль, цэцэрлэгээ улсын төсвөөс гадна тусгаж чадна. Түүний зэрэгцээ яах вэ энэ 2026 онд бид бас энэ дуусгах эхэлчихсэн ийм барилгууд байна. Тэгэхээрээ энэ дээр бол нийтдээ 44 сургууль дуусах нь ээ. 48 цэцэрлэг дуусах нь, 14 дотуур байр ашиглалтад оруулах ийм төлөвлөлттэй явж байгаа.

Тэгэхээрээ бид бас энэ дунд хугацааныхаа зорилгод хүрэхийн тулд энэ ажлуудыг шуурхайлах ийм бас шаардлага байна гэж харж байгаа. Үүний тулд бас төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг нэлээн сайн хүчтэй тавих ёстой юм байна. Хувийн барилгын компаниуд орж ирээд сургууль барьсан тохиолдолд, цэцэрлэг барьсан тохиолдолд тэрийг нь улс дээр түншлэлийн хүрээнд, концессын хүрээнд худалдан авах ийм үйл ажиллагааг хийх юм бол яг эцэстээ илүү үр дүнтэй байх нь харагдаад байна л даа. Энэ дээр үед бас энэ концессын хууль бас нэлээн өндөр үнэлгээтэй ийм төслүүдийг авч хэрэгжүүлснээс болж төсөвт нэлээн дарамт учирч байсан юм байна лээ. Харин одоо илүү хариуцлагыг хувийн хэвшлээс ч гэсэн шаардаад тэгээд хүн амын нягтрал ихтэй газруудад сургууль, цэцэрлэг барьсан тохиолдолд бол энийг нь төр дээр сургууль, цэцэрлэг болгож авах, эсвэл газрыг нь чөлөөлүүлж тэрэн дээрээ хувийн хэвшилтэй ярилцаж 2 жилийн дотор барилгыг барьдаг ийм л хугацаа хэмнэсэн мөнгө хэмнэсэн ийм систем рүү орохгүй бол манай энэ улсын төсөв дээр тавигдаж байгаа нь ихэвчлэн 3 жилээр он дамнадаг хамгийн багадаа 2 жил байдаг.

Тэгээд ингээд он дамнасныхаа явц дундаа тарифын шинэчлэл хийгдсэн үнэ нь нэмэгдсэн гээд үнийг нь барих зардлыг нь нэмчихдэг ийм л нөхцөл байдлаар явдаг. Түүний зэрэгцээ материалын үнэ өссөн инфляц эд нар гээд ингээд төсөв дээр яг үнэндээ сунжрах тусмаа ихээхэн дарамт авчирч байгааг нуулгүй хэлэх ёстой. Ийм учраас хувийн хэвшлийн энэ төр хувийн хэвшлийн түншлэлийг энэ салбар руу илүү түлхүү татаж оруулах нь зүйтэй байна гэж харж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Тодруулах уу Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Тэгэхээр Наранбаяр сайдаа энэ 45 сургууль, 45 цэцэрлэг эхэлнэ гэж яриад байна. Би бол одоо өөрөө бас шинээр эхлэхийг яриад байгаа. Үргэлжилж саяын ашиглалтад 2026 онд нь багтаагаад ашиглалтад оруулчихъя гэж байгааг бол ингээд дэмжээд үргэлжилж байгаа төслүүдийг хараад байгаа. Шинээр орох юман дээр ер нь АХБ-ны 41 төсөл арга хэмжээ буюу 32 сургууль гээд орж ирсэн. Тэгээд өнөөдөр яг энэ төлөвлөгөө дотор ороод ирэхэд тэр АХБ-ных гэж би ойлгоод байгаа. Гадаадын зээл тусламж 468 тэрбум төгрөг байгаагаас 2026 онд ерөөсөө 0 байгаад байгаа юм. Ямар ч эндээс нөгөө төлөвлөлт төсөв тавигдаагүй ийм 4.1.7 дээр ингээд ороод ирчихсэн байж байгаа шүү. Би энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад энэ дээр 93 тэрбум төгрөгийг оруулъя гэдэг би ийм юм тавьж байгаад энэ мэтчилэн ингээд зөрүүтэй тоо байгаа учраас нягтлах хэрэгтэй байна аа.

Б.Найдалаа: Наранбаяр сайд 4 номер.

П.Наранбаяр: Ойлголоо. Тэгэхээр энэ төлөвлөлт дээр ороогүй бол энийг нь засварлаад зарчмын зөрүүтэй саналаар оруулах нь зүйтэй. Ажлын хэсэг дээрээ ярилцаж байгаад энийг нь оруулах нь зүйтэй. Яагаад гэвэл энэ АХБ-ны энэ юу маань харилцан гэрээн дээр гарын үсэг зуралцсан байгаа. Үүний дараа соёрхон батлуулах ажил явагдана. Тэгэхээр энэ соёрхон батлах ажиллагааны дараа энэ 12 сарын эхээр ADB-ийн удирдах зөвлөлийн хурал дээр манай яамны төлөөлөл бас оролцоно. Тэгээд энэ чиглэлээрээ бид аль болохоор ирэх оны хавраас эхлээд энэ ажлуудыг эхлүүлэхээр ингэж төлөвлөөд ажиллаж байгаа учраас энэ дээр хэрвээ 0 гээд дууссан энэ ажлын хэсэг дээр ярилцаж байгаад засварлаж оруулъя. Баярлалаа.

Б.Найдалаа: Галбадрах гишүүн дахиад тодруулъя.

Ж.Галбадрах: Сангийн яам бас байж байгаа. Энэ дээр энэ боломж байгаа юу гэдгийг Дэлгэржаргал даргаас бас асуумаар байна. Тодруулж яагаад гэвэл бид нар АХБ-аар тэр 108 сургууль, 95 цэцэрлэг энэ чинь бол одоо 1 ангид байх, бүлэгт байх хүүхдийн тоог 40-өөс доош оруулах л гэдэг бид нар тийм том зорилгын төлөө л явж хийж байгаа том асуудал байж байгаа. Би бол ерөөсөө л сургуулийн хүртээмжтэй асуудлыг л тууштай яриад яваад байгаа. Гэтэл одоо өнөөдөр тэр нөгөө стандарт хангасан сургуулийн барилгын тоо, 76 хувь тэр нь бол бүүр 30-аас доош хүүхэдтэй нь 76 хувь ч гэдэг юм уу ийм зөрөөтэй зөрөөтэй тоонууд их гарч ирж ингэж яваад байгаа.

Тэгэхээр би Сангийн яамнаас асуучихмаар байгаа юм. Ийм АХБ-ан дээр 0 гэж тавьсан байж байгаа. Тэр гадаадын зээлийн юмыг нэмэх тийм боломж нь бас байгаа юу? Сая Наранбаяр сайд хариулсан.

Б.Найдалаа: Сангийн яамнаас саяын асуултад хариулна. Микрофон 6.

Дээр нь Галбадрах гишүүний түрүүний нэг асуулт орхигдоод байна. Хөгжлийн төлөвлөгөөнд орчхоод төсөвт суудаггүй. Энэ яг яагаад яваад байдаг юм аягүй олон асуудал дээр юм гарч байгаа. Тэрийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуумаар байна. Сангийн яам уу хэн хариулах юм? Баахан юм төлөвлөгөөндөө оруулчихдаг төсөв байхгүй. Микрофон 6-г нээе.

Ж.Дэлгэржаргал: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. АХБ-ны төслийн хувьд бол яг энэ боловсролын хүртээмжтэй холбоотой 41 барилга байгууламжийг хэрэгжүүлэх 150 сая ам.долларын санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр Улсын Их Хурлаас дээр соёрхон батлах ийм процесс явж байгаа. Гадаад зээлийн төслүүдийн хувьд бол зээлийн ашиглалтын дүн буюу зээлийн эх үүсвэрээсээ тухайн жилд хэдийг яаж ашиглах вэ гэдэг дүн нь өөрөө төсвийн тухай хуулиараа Сангийн сайдын багц дээр багц дүнгээр батлагддаг. Ирэх жилийн хувьд бол 1.2 их наяд байгаа. Тэгэхээр энэ 1.2 их наядаас төслүүд маань гүйцэтгэл нь гарсан тохиолдолд бид нар яг энэ хэлэлцээр нь батлагдсан төслүүдийнхээ хувьд бол санхүүжилтийг олгоод явдаг учраас 2026 онд энэ АХБ-ны төслүүд гүйцэтгэл гарах юм бол санхүүжилт олгох бүрэн боломжтой.

Хоёр дахь асуулт нь жилийн төлөвлөгөө болон төсвийн уялдаа холбооны асуудал байна.

Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд бол.

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд бол жилийн төлөвлөгөөтэй уялдсан дээр Сангийн яам бас судалгаа хийдэг. Тухайлбал 2026 оны жилийн төлөвлөгөө, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2 харьцааг харах юм бол жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 19 их наядын хэрэгцээтэй байхаар Улсын Их Хурлаас баталсан. Үүн дотроосоо яг эх үүсвэрээр нь салгаад үзэх юм бол 3.6 их наяд нь улсын төсвийн хөрөнгө оруулалт байна гээд. Гэтэл сая батлагдсан хөрөнгө

оруулалт маань 3.2 их наяд байгаа. Нөгөө талдаа ийм эх үүсвэрүүдийн хэрэгцээ шаардлагын асуудал гарч.

Хоёрт нь болохоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль дээр яг жилийн төлөвлөгөөнд ороод батлагдсан ч гэсэн Төсвийн хуулийн шаардлага хангахгүй бол төсөв дээр тусгагдах боломжгүй байдаг. Яг хэрэгжүүлнэ гээд орчихдог бэлэн зураг, төсөв газар гээд төсвийн хуулийнхаа шалгуур үзүүлэлт эрэмбийг хангахгүй бол бид нар төсөв дээр тавьж чаддаггүй. Тэгэхээр жилийн төлөвлөгөөнд орсон 45 сургууль шинээр эхлэх энэ зорилтдоо сая төсөв батлагдахдаа хүрсэн. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн явцад сургуулиудын барилга шинээр нэмэгдээд улсын төсвийн хөрөнгө оруулалт АХБ нийтдээ 45.

Б.Найдалаа: Ганмаа гишүүн асуулт асууна. Тэрнээс өмнө би 1 асуух юм үг хэлээдэхье.

Түрүүн Галбадрах гишүүний асуултууд болон саяынх яг маш чухал асуудал байгаад байна. Саяын энэ төсөв батлахтай холбоотой төлөвлөгөө батлахтай холбоотой нийтлэг асуудал. Хөгжлийн төлөвлөгөөгөө бид нар ийм хүслийн жагсаалт болгож баталж хаячхаад бүгдэнгийн хүслийг багтаагаад томоо юм хийчихдэг. Эргээд яг хөтөлбөр төсөвт тавихдаа тухайн үед хэн илүү эрх мэдэлтэй мэдээлэлд ойрхон ч юм уу төсвөө дөвийлгөөд тавьчихдаг. Эргээд сүүлд нь гол асуудлууд нь орхигдоод байх шиг байгаа юм. Тэгэхээр уг нь Эдийн засгийн хөгжлийн яамны оршин байж байгаа үндэс нь ердөөсөө саяын тэр хөгжлийн төлөвлөгөөнд байгаа ажлуудыг эрэмбэлэх л гэж би ойлгоод байгаа байхгүй юу. Тэрийгээ дутуу эрэмбэлснээс болоод төслийн жагсаалт болон хүсээгүй төсөв 2 ингээд ерөөсөө хэрэгжихгүй. Тэгээд тэр нь гишүүд болон иргэд бухимдаад байгаа нь энэ гэж бодож байгаа юм.

Тийм болохоор уг нь бол Эдийн засаг хөгжлийн яамны оршин тогтнож байгаа ганцхан зорилго нь ердөөсөө л энэ гэж бодож байгаа юм. Тэгээд энэ дээрээ жоохон шинэчлэл хийхгүй бол бүх юмыг багтаачхаад сүүлд нь төсөв нь угаасаа хүрэхгүй нь ойлгомжтой шүү дээ. Тэгээд тэр төлөвлөгөө боловсруулалт дээрээ төсвөөсөө илүү бараг илүү анхаарал хандуулмаар санагдаад байгаа юм аа.

Хурлаа цааш нь үргэлжлүүлье. Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу?

Өнөөдөр бид нар энэ хөгжлийн чиглэлээ ярьж байхдаа бас намын төлөөллүүд байгаа учраас гол нь энэ салбар хоорондын уялдааг яаж энд оруулж байгаа? Бид нар чинь ингээд хараад байхад яам болгон өөрсдийнхөө бодлогыг гаргаад тэгээд эдийн засгийн яаман дээр ч юм уу засаг дээр эрэмбэлээд ордог гэж бодож байсан боловч ингээд төсвийг харж байхад бол тэр үгүй байна гэдгийг нь мэдлээ шүү дээ. Тэгэхлээр энд нэгэнт ингэж яамны төлөөллүүд байгаа учраас эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгэм, хамгаалалттай уялдаа холбоог нь яаж хангах юм гэдэг тэр механизмуудыг та нар гаргаж ирж боловсруулж оруулсан уу? Энэ дээр энийгээ яаж дүгнэх юм гэдэг нэг асуулт байна.

Жишээлбэл эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр дээр ийм бодлогын уялдаа юм уу. Энэ нь алдагдаад энэ чиглэл биелээгүй боловсрол гарч ирээгүй тохиолдолд яг энэ хариуцах эзэн нь байгаа юу? Хэнтэй бид нар хариуцлага

тооцох юм гэдэг нь 2 дахь асуулт. Энэ 2026-2030 онуудад энэ боловсролын системийг үндэсний хөгжил тэгээд хөдөлмөрийн зах зээл технологийн шилжилттэй яаж уялдуулж бас оруулж ирж байгаа вэ гэдгийг асуумаар байна. Тэгээд яам тус бүрээс тусад нь асуухад эрүүл мэндийн салбар дээр жишээлбэл сая тэгэхдээ Галбадрах багшийн асуусан дээр би бас бодож байлаа. Одоо энэ Оюун-Эрдэнэ сайд Ерөнхий сайд байх үед бид нар нөгөө эрүүл мэндийн жилийг боловсролын жилийн дараа шууд оруулж ирье гэдгийг яриад төлөвлөгөөнд нь тусгах талаар асуудал яригдаж байсан боловч энэ 2026 онд боловсролын жил гэж зарласан мөртөө төсөв дээр мөнгө тавигдахгүй байна гэдэг чинь аягүй бид нар сурч авч байна шүү дээ хараад.

Тэгэхээр эрүүл мэндийн жил болгож дараа жилийг зарласантай холбоотой дэд бүтцийг яаж байгуулах юм. Бодлогын энэ уялдаа холбоогоо энд бас яаж оруулж ирсэн бэ гэдгийг асуумаар байна. Дэд бүтцийг нь яаж бэлдсэн ялангуяа. Эрүүл мэнд дээр яг тусад нь жишээлбэл өвчинг эмчлэх биш ер нь урьдчилан сэргийлэх зарчмыг эрүүл мэндийн гол бодлого болгоё оо гэж хариулж байна тийм үү? Тэгэхээр ингээд гол тодорхой арга хэмжээ нь яг юу байх юм гэдгийг асуумаар байгаа байхгүй юу. Сая сайд хариулахдаа тэр биеийн тамир цусан дахь өөхний хэмжээ таргалалтыг бууруулна гэж байна. Тэгэхдээ энэ чинь шим тэжээл зайлшгүй орж ирэхгүй бол энэ саяын тэр нийгмийн эрүүл мэндийн асуудлын нэг гол багана алга болох гээд байна. Энийг яаж ямар ки пи ай-аар шалгаруулна гэж эндээ тооцоолж оруулж ирсэн бэ гэдгийг мэдмээр байна. Нас баралтын тэргүүлэх шалтгаан байгаа тиймээ? Хавдар байгаа зүрх судасны өвчлөл байгаа, осол байгаа. Энийг яг нас баралтыг хэдэн хувиар бууруулна гэж оруулж ирсэн бэ? Жил жилээр гаргасан тооцооллоо яаж тооцсон бэ гэдгийг асуумаар байна.

Хот хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагын хүртээмж гэж байгаа. Энэ хүртээмж дээр бас энийг яаж ялгааг нь өөрчилье гэж оруулж ирсэн юм, яаж бууруулах юм. Ингээд зогсчихъё.

Б.Найдалаа: Хариултыг Чинбүрэн сайдаас эхлэх үү? Наранбаяр сайд. Микрофон 2.

Х.Сүрэнхорол: Эдийн засаг хөгжлийн яам Сүрэнхорол. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу салбаруудын бодлогын уялдааг хангаж холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж оруулж ирэх ёстой. Энэ агуулгаараа бол хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийнхаа хүрээнд 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа 4 түвшний үр дүнг боловсруулж орж ирсэн. Энэ хүрээнд өөрөөр хэлэх юм бол үндэсний 10 үр дүн. Үндэсний хэмжээнд бид нар ямар 10 үр дүнг зорих юм бэ? Салбарын 35 буюу салбарынхаа боловсрол, эрүүл мэнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр салбарын 35 үр дүн, төсвийн ерөнхийлөн захирагчийн 85 үр дүн. Хөтөлбөрийн 200 үр дүн гээд нийт 330 үр дүнг тодорхойлж орж ирсэн. Энэ хүрээндээ болохоор 8 үндсэн чиглэлийг бол 5 жилийн үндсэн чиглэл маань өөрөө болохлоор 8 үндсэн чиглэлээс бүрддэг. Хүний хөгжил, нийгмийн хөгжил ч гэдэг юм уу 8 үндсэн чиглэлээс бүрдэж байгаа. Энэ 8 үндсэн чиглэл маань цаашаа болохоор өөрөөр хэлэх юм бол нөгөө үндэсний 10 үр дүн. Салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн гээд үр дүнгүүд маань ингээд салаад яваад ирэхээр өөрөөр хэлэх юм бол энэ маань ингээд 8 үндсэн чиглэл дээрээ бүх салбарууд маань нэгдэж орж ирж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр бодлогын уялдаагаа гаргаад үр дүнгүүдээ тусгаад явж орж ирж байгаа юм аа.

Б.Найдалаа: Дараагийн хариулт Чинбүрэн сайд микрофон 3.

Ж.Чинбүрэн: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Бид ер нь хэмждэг нөгөө үзүүлэлтүүдээ их тодорхой тавьж ямар үр дүнд хүрэх гэж байгаагаа энэ 5 жил дотроо тодорхой болгоод түүндээ зориулсан санхүүжилт төсвүүдийг нь зангидаж дээрээс нь олон яамдуудын уялдаа холбоог зангидах нь ерөөсөө л энэ 5 жилийн гол ажлын үр дүн.

Тийм учраас нөгөө хариуцах эздүүдийг нь бид нар дараагийн баганад нь оруулчихсан та бүхэнд харуулаад байгаа. Урьдчилан сэргийлэх чиглэлд гол хийх гэж байгаа ажлууд юу байгаа юм бэ гэж асууж байна. Тэгэхээр 1-д бол эрт илрүүлэг их оновчтой үргэлжлэх ёстой. Эрт илрүүлэгт хамрагдах хувийг энэ тоон үзүүлэлтээр оруулсан байгаа. Вакцинжуулалт бол бас анхдагч урьдчилан сэргийлэлтийн бас нэг чухал зүйл байгаа. Тэгэхээр вакцинжуулалтын үйл ажиллагааг бас тодорхой түвшинд хүргэхээр энэ заалтуудыг оруулсан байгаа. Эрүүл мэндийн боловсрол олгох л их чухал. Ялангуяа энэ сургуулийн насны хүүхдэд антропологийн хэмжилтүүдийг хийж, өсөлт хөгжил нь хэмжээндээ байгаа эсэхийг мэддэг байх.

Б.Найдалаа: Ганмаа гишүүн тодруулах уу? Тодруулчхаад хариултаа авах уу? Ганмаа гишүүний микрофоныг нээе.

Д.Ганмаа: Хариултаа дуусгуулчих уу?

Б.Найдалаа: Гүйцээж хариулна Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Дараагийн зүйл би түрүүн нөгөө зуршил гэж ярьсан тиймээ жишээлбэл архи тамхи, илүүдэл жин энэ буруу зуршлыг сайн хэвшил рүү шилжүүлэх энэ үйл ажиллагаа энийг бас Спорт, аялал жуулчлалын яамтай хамтарч хийхээр антропологийн үзүүлэлтүүдийн нэг хэвийн хэмжээнд байх 70 орчим үзүүлэлтийг 76 хувийг нэг 81-тэй болгоё энэ тэр гэсэн ийм том зорилтууд байж байна аа. Халдварт бус өвчинтэй холбоотой нас баралтыг бууруулах заалтууд тоон үзүүлэлтүүд бас орсон байгаа тийм ээ. Харвалт, шигдээс, хорт хавдар, чихрийн шижин гээд одоо энэ чухал зүйлүүдийг тэр дотроо бас сэтгэцийн эрүүл мэндийг бас давхар оруулсан байгаа.

Хүртээмжийг яаж бууруулах вэ гэж байна. Тэгэхээр энэ дээр бид даатгалын тогтолцоог сайжруулах, дээрээс нь нэг иргэний карманаас гарч байгаа зардлыг бууруулах гэдэг тоон үзүүлэлтийг бас энд оруулсан байгаа. Тэр зорих үзүүлэлтүүд орсон байгаа.

Б.Найдалаа: Наранбаяр сайдад хариулт байгаа юу? Микрофон 4.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ салбар хоорондын уялдаа туйлын чухал. Боловсролын салбарын хувьд бол ер нь улс орны ирээдүйг авч явах ийм ажиллах хүчин ирээдүйн том сэхээтнүүд ийм хүмүүсийг бэлдэн гаргаж байдаг учраас аль ч салбартай нь уялдаж ажиллах ёстой. Тэгээд энэ хүрээндээ бид бас энэ 5 жилийнхээ хөтөлбөр төлөвлөгөөнд бол хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөцийг бэлтгэнэ гэсэн ийм маш чухал зорилтыг дэвшүүлсэн байдаг.

Тэгэхээр зэрэг энэтэй холбоотойгоор жишээлэх юм бол эрүүл мэндийн салбартай яаж уялдах вэ гэхээрээ эмчийн зохистой тоо хэд байх юм бэ? Өнөөдөр эмчийг 7 их дээд сургуулиудад бэлдэж байна. Ингээд эмч нь бол зах зээлийнхээ хэрэгцээнээс хэтэрсэн ийм байдлаар бэлдээд сувилагч нь дутаад ирсэн байх жишээтэй. Ийм зүйлүүдийг бол бид Чинбүрэн сайдтай мөн ЭМЯ-тайгаа ярилцаад энэ салбар хоорондын уялдааг хангах энэ ажлуудыг хийх юм аа.

Тэгэхээр энэ боловсрол бол бүхий л салбартай нь ингэж хамтран ажиллаж хөдөлмөрийн зах зээлтэй нь уялдсан ийм ажлыг Хөдөлмөрийн яамтайгаа хамтраад ингээд хийж байгаа шүү гэдгээ хэлье. Баярлалаа.

Б.Найдалаа: Ганмаа гишүүн тодруулна.

Д.Ганмаа: Яах вэ саяын асуултуудыг хүлээгээд авчихъя. Үргэлжлүүлээд тэгвэл асууя даа. Одоо энэ жишээлбэл Боловсролын сайдаас асуухад нөгөө бид нарын чинь Монгол хүүхдүүдийг харьцангуй IQ-ийн хэмжигдэхүүн нь гайгүй гараад байдаг мөртөө писа үнэлгээгээрээ их доогуур үзүүлэлт гарчихсан гээд нэг хэсэг нэлээн болсон шүү дээ. Тэгэхээр энэ 2026-2030 онд сурагчдын писагийн үзүүлэлтийг хэдэн оноогоор өсгөнө ч гэдэг юм уу тийм Ки Пи Ай-ийн зорилт ч юм уу эсвэл чиглэл оруулж ирсэн тодорхой тоогоор ялангуяа хэлэх боломж байгаа юу? СӨБ-ын хүртээмжийг хот, хөдөөгөөр бас энэ ялгааг нь бууруулах дээр ч юм уу тийм хэлсэн ярьсан тооцоолсон юмнууд бодлогын юмнууд байгаа юу? Мэргэжлийн болон техникийн боловсрол гэж байгаа тиймээ? Тэрний төгсөгчдийн ажлын байрны топ 10 чиглэл ч юм уу эсвэл энэ нь хувийн хэвшилтэйгээ яаж хамтарч явах вэ гэдэг дээр тийм бас.

Б.Найдалаа: Микрофон 4.

П.Наранбаяр: Энэ яг писагийн асуудал хөндөж байна. Писа дээр Монгол улс яг жоохон сул оноо авчихсан нь тэр унших чадвар дээр байгаад байгаа. Тэр нь зүгээр минутын уншлага биш шүү дээ. Уншаад ойлгоод ойлгосноо хэрэглэж чадаж байна уу, үгүй юу гэдгийг л асуусан ийм писагийн ийм шалгалт байсан. Энэ дээр нэлээн бас Монгол Улс сул оноо авсан учраас унших чадварыг дээшлүүлэх чиглэл рүү бид нэлээн ажиллаж байгаа. Сургуулийн боловсролын яг хөтөлбөр дээрээ бага сургуулийнхаа хөтөлбөр дээр бол унших бичгийг сэргээж оруулж ирэх энэ ажлыг хийж байгаа гэдгийг хэлье. Яг өсгөх тоо нь бол яг байсан. Манайхан хэдээр байлаа Оюунаа хэдээр байсан юм. Писагийн үнэлгээг тэдээр өсгөнө гээд. 1.1.2 дээр хэдээр байсан юм айн? Тийм тэгэхээрээ 1.1.2 дээр бид урагшлуулах дүнг нь яасан энийг нь бид бас танд тоог нь хараад хэлээд өгье. Нөгөө талдаа СӨБ-ын хүртээмжийн асуудлыг та хөндлөө.

Б.Найдалаа: Тэгэхээр гүйцээж хариулъя. 4.

П.Наранбаяр: СӨБ-ын хамран сургалтыг бол 2025-2026 оны хичээлийн жилийн байдлаар 92.6 хувь болгож өмнөх жилээс бол 1.6 хувиар өсгөсөн. Цаашдаа энэ тоог 95, бүүр 100 хувь руу оруулах ийм зорилт тавиад ажиллаж байгаа. Ялангуяа 5 настныг сургуульд бэлдэх нь их чухал байдаг. Энэнтэй холбоотойгоор бид бас 5 настай хүүхдийн сургууль бэлдэх энэнтэй холбоотойгоор энэ СӨБ-ынхоо хөтөлбөрийг шинэчлээд өнөөдөр ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Энэ дээр хүүхдийн дасгал ажлын дэвтэр, багшийн гарын авлага гэсэн зүйлүүд хэвлэгдээд тараагдахаар бэлтгэл ажил нь хангагдаад явж байна аа. Баярлалаа.

Б.Найдалаа: Ганмаа гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганмаа: Энэ салбар хоорондын уялдаа гэж асуусан шалтгаан нь бас би чуулган дээр бас Учрал сайдаас асууж байсан. Эдийн засаг, хөгжлийн сайд гэсэн утгаараа. Одоо жишээлбэл эрүүл мэндээр гэхэд бид нар тэр эрүүл мэндийн хэрэгцээний үнэлгээ гэдэг юмыг өнгөрсөн жил бас л өмнөх засагт боловсруулаад өгч байсан юм. Тэр төсөл жишээлбэл хаана явж байгаа юм. Сая жишээлбэл Боловсролын яамнаас хариулж байна шүү дээ. Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд тулгуурласан хүний нийлүүлэлт гээд. Тэрүүн шиг яг эрүүл мэндийн хэрэгцээний үнэлгээг хийж байж тэрэн дээрээ тулгуурласан бид нар тэр өвчлөл, шалтгаант нас баралт, урьдчилан сэргийлэлт. Тэр байтугай төсвийн тооцоолол тэрүүгээрээ явах ёстой байхгүй юу. Энэ яг хаана явж байгаа юм? Энэ салбарын асуудал уу? Одоо тэр эсвэл ЭМЯ эзэн биетэйгээр энийг хариуцаж сайд явна гэж байна уу? Энэ дээр нэг тодруулчихъя тэгэх үү.

Б.Найдалаа: Микрофон 3.

Ж.Чинбүрэн: Хэрэгцээний үнэлгээ ерөөсөө хамгийн чухал зүйл. Ер нь бид энэ ирэх 5 жилд эрүүл мэндийн хэрэгцээ бидэнд ямар нөөц боломж байгаа юм. Ямар хөрөнгө оруулалт хийх юм, юуг гүйцээж, бид ард иргэддээ 3.6 сая иргэдээ яаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх вэ гэдгийг л гол бичиг баримт байна гэж ойлгодог. Тэр ч утгаараа энэ ЭМЯ өөрөө энийг манлайлж хариуцаж, дээрээс нь бид бас Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль гарсантай холбоотой энэ салбар хоорондын уялдааг хангасан зөвлөл энэ Үндэсний зөвлөл энэ тэр байгуулагдах ёстой. Энүүгээрээ дамжуулаад Засгийн газар дээр Эрүүл мэндийн яам өөрөө энийг манлайлж ажиллах ёстой гэж харж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганбатын Хосбаяр гишүүнийг асуух асуулт гишүүнд нэмээдхээрэй. Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? 5 жилийн ер нь ингээд урт хугацааны төлөвлөгөөг харахаар дэлхийн олон орнууд урт хугацааны төлөвлөгөө дээрээ барьдаг нэг чухал зүйл бол аз жаргалын үзүүлэлтүүд байдаг. Та бүхэн аз жаргалын репортуудыг бас сонсож байсан байх. Тэгэхлээр манай улс бие дааж энийг гаргадаггүй. Одоогийн байдлаар Монгол Улсад ахмад настнуудын хувьд 2 ахмад тутмын нэг нь ганцаардаж байгаа сэтгэл гутралын асуудалтай байдаг. Залуучуудын хувьд маш их стресстэй. Ажил эрхэлж байгаа хүмүүсийн ажил амьдралын тэнцвэр алдагдсан энэ талаар ер нь тоймтой судалсан юм бас ярьдаггүй. Хотын орчин бол тэр чигтээ стресстэй тиймээ. Тэгээд нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд бол хүртээмжгүйгээс болоод маш бухимдалтай дам асуудлууд байна. Тэгээд хүүхдүүд рүүгээ орох юм бол өсвөр үеийн хүүхдүүд ялангуяа амиа хорлох сэдэлтэй, сэтгэл гутралын үзүүлэлтүүд маш өндөр байгаа.

Тэгэхээр би энэ 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөнөөс яг энэ хүний хөгжилтэй холбоотой, нийгмийн хамгаалалттай холбоотой заалтыг харж байна л даа.

Тэгэхээр саяын миний асуудлуудыг хөндсөнчлөн шийдэж хэмжих нэг үзүүлэлт дэлхийн улс орнуудын аз жаргалын индекс байхгүй юу. Аз жаргалын үзүүлэлтүүд байгаа. Тэгэхээр манай орон ер нь хэзээ энийгээ гаргах вэ? Дэлхий дээр 2 зуугаад орон энэ үзүүлэлтүүдээр хэмжиж гаргаж байгаа. Энэ үзүүлэлтүүд нь

юуг харуулдаг вэ гэхлээр ДНБ-ий өсөлт иргэдийн амьдралд хэрхэн тусаж байгааг илэрхийлдэг ийм л үзүүлэлт байгаа. Энэ дээр бас та бүхэн маань мэдэх байх. Энэ дээр нэг хариулт авъя гэж бодож байна. Дараа нь жишээ авъя л даа. Би гэр бүлийн бодлогыг дэмжих гэдэг ийм арга замыг хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлэх үр дүнг үр дүнгээр хэмжинэ гэсэн байгаа юм. Тэгээд шалгуур үзүүлэлтүүд нь хүн амын дундаж өсөлт гэнэ ээ.

Тэгэхээр стресс бухимдал, гэр бүлийн салалт ихтэй байгаа үед үндэсний нэгдмэл хөгжил гэдэг хүрээнд гэр бүлийн бодлогыг дэмжье гэхээр хүнээ өсгөх тухай л, хүүхэд төрүүлэх тухай л яриад байх юм уу гэдэг ийм зарчмын хувьд нэг жоохон ийм ойлгомжгүй юмнууд харагдаад байна. Жишээлбэл нөхөн үржихүйн талаарх мэдлэгийг дээшлүүлнэ гэнгүүтээ жирэмсний хяналтад хамрагдалтыг нэмэгдүүлнэ гэж байгаа юм. Өсвөр насны 11 настай охин Монголд төрж байгаа шүү дээ. 11, 12-той. Бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр чиглэсэн иймэрхүү асуудлууд руу чиглэсэн ийм шалгуур үзүүлэлтүүд ийм үр дүн байна уу гээд харахлаар бас сайн харагдахгүй байна л даа. Тэгэхээр энэ зүйлүүд дээр ер нь ямар төлөвлөгөө энэ номд багтаагүй, харагдаагүй ямар төлөвлөгөө байгааг тодруулъя. Ялангуяа сэтгэцийн эрүүл мэнд гэж дөхүүлье л дээ. Аз жаргал хол байж болно. Тэгээд дараа нь тодруулъя.

Б.Найдалаа: Хариултыг микрофон 2.

Х.Сүрэнхорол: Яах вэ 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулах явцад бид нарын тулгарсан нэг бэрхшээл юу байсан бэ гэхээр зарим шалгуур үзүүлэлтийг ерөөсөө одоогоор тооцож чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр болохлоор нөгөө нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийг тооцож байгаа үзүүлэлт одоогоор байхгүй. Дэлхийн улс орнууд энийгээ тооцоод явдаг. Тэгэхлээр бид нар энийгээ тооцдог болох хэрэгтэй. Ямар ч байсан 2025 оноос бол ингээд энэ оноос 5 жилийн үндсэн чиглэл 2026 оноос 5 жилийн үндсэн чиглэл маань хэрэгжиж эхэлнэ. Тэгэхээр энэ хугацаанд бэлтгэл ажлаа хангах хэрэгтэй. Аргачлалаа тооцох хэрэгтэй. Тэгээд яах вэ нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ гэдэг 4 дүгээр бүлэг дээр бас үр дүнгүүдийг бас тусгаад явчихсан байгаа. Тэгээд энэ хүрээндээ болохлоор манай улс 2030 онд бол 20 хувиар ахиулна гэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол тооцчихоод тэр тооцсон үнэлгээгээ 2030 онд 20 хувиар нэмэгдүүлнэ.

Тэгэхээр тэрийгээ аргачлалаа эхлээд батлах ёстой аргачлалынхаа аргачлалаа баталсныхаа үр дүнд тооцох хэрэгтэй. Тооцоод тэр үнэлгээгээ 2030 онд 20 хувиар нэмэгдүүлнэ л гэсэн шалгуур үзүүлэлт хүрэх түвшнийг тогтоож өгч байгаа. Дээрээс нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ дээр нэмж хариулах ёстой байх тиймээ.

Б.Найдалаа: Микрофон нэг.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул гишүүний асуултад хариулъя. Манай дээр болохоор гэр бүлийн ээлтэй тогтвортой байдлыг хангана гэсэн ийм зорилт хүлээгдэж байгаа. Үр дүн тавьж байгаа. Энэ үр дүнгээ хэмжих шалгуур үзүүлэлт маань мянган хүн тутамд ноогдох гэр бүл цуцлалтын тоог бууруулахаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоог бас бууруулахаар мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн хүрээнд гэр бүлийн

хүчирхийллээс болж хохирсон хүүхдийн тоог бууруулахаар, салбар дундын уялдааг хангах зорилгоор хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд тогтмол хамрагддаг хүүхдийн тоог нэмэгдүүлээд үүний үр дүнг хоол тэжээлийн дутагдалтай буюу туранхай хүүхдийн тоог байхгүй болгох өсөлтийн хоцрогдолтой 5 хүртэлх насны хүүхдийн тухайн насны хүүхдэд эзлэх хувийг бууруулахаар тус тус үзүүлэлтүүд оргосон байгаа. Тэгээд сэтгэл зүйн талаас нь тодорхой үзүүлэлт бас шууд нэрлэчихээр зүйл байхгүй байна.

Тэгээд зарчмын зөрүүтэй санал гарч ирэх юм бол.

Б.Найдалаа: Баярлалаа. Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал дээр тодруулъя.

Б.Найдалаа: Микрофон 3.

Ж.Чинбүрэн: Саранчулуун гишүүний чухал хөндөж байгаа зүйл энэ хүний хөгжлийн үзүүлэлт л дээ. Тэгээд бид энэ гол энэ бичиг баримтад оруулж байгаа зүйл бол хүний хөгжлийн үзүүлэлт. Тэр дотроо хүний хөгжлийн үзүүлэлтийн гол бүрэлдэхүүн хэсэг нь бол энэ эрүүл мэндийн асуудал байдаг. Энэ насжилт боловсрол амьжиргааны түвшиндээ уясан. Тэгэхээр энэ эрүүл мэндийн одоо Монгол улс энэ хүний хөгжлийн үзүүлэлтээрээ 0.74 буюу нэг дундаж өндөр үзүүлэлттэй байгаа бол энэ 5 жилийн хугацаанд бид энэ өндөр хүний хөгжилтэй буюу 08-аас дээшээ гарсан ийм үзүүлэлттэй больё гэж байгаа. Энэ дотор гол үзүүлэлт ерөөсөө л эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй хүргэж чаддаг, дээрээс нь хүмүүс нь урт удаан чанартай амьдарч чаддаг. Өвчнөөс болоод нас баралтыг бууруулна л гэсэн ийм том зорилтыг энэ 5 жилийн юунд орсон байгаа. Мөн давхар энэ халдварт бус өвчин гэдэг дотор сэтгэцийн эрүүл мэндийн асуудал өөрөө орж байгаа. Тэгэхлээр энэн дээр бас танд мэдээ дэлгэрэнгүй мэдээлэл өгье. Бас нэг чухал зүйл.

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя 3 номер.

Ж.Чинбүрэн: Нөхөн үржихүйн асуудал бас дурдагдаж байна. Тэгэхээр энэ бас эрүүл мэндийн салбарын нэг томоохон нэг зүйл өсвөр насны охидуудын жирэмслэлтийн эзлэх хувийг бууруулах.

Дээрээс нь амьд төрөлтийг үр хөндөлттэй харьцуулсан харьцааг бас абартыг бууруулах гэсэн ийм 2 чухал зүйл үзүүлэлтүүд орсон шүү.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулж асууна.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгвэл оруулахаар төлөвлөж байгаа гэж ярьж байна тиймээ? Нийгмийн сайн сайхан байдлын үзүүлэлтийнхээ яг хэмжүүрийг тодорхойлоогүй бол бид нар аз жаргалын гэж яриад байгаа дээр дэлхийн 10 төрлийн үзүүлэлт байна шүү дээ. Дэлхийн статистикийн хороо хэрэглэж байна. Тэрнээс бүгдээрээ авч энэ аз жаргалын индексүүдийг оруулж өгөх нь 5 жилийн төлөвлөгөө ярьж байгаа үед маш чухал байхгүй юу. Энүүгээрээ бид нар жинхэнээсээ ДНБ хүмүүсийн амьдралд яаж хүрч байгаа гэдгийг ярина. Дээрээс нь бид нар одоо өнөөдөр энэ номд байгаа туссан бүх үйлчилгээ чинь өвдсөн хүмүүсийг

сэргийлэх, эсвэл эмнэлэгт очсоны дараа л авах үйлчилгээнүүд түлхүү байгаа байхгүй юу.

Гэтэл эмнэлэгт очоогүй, оношлогдоогүй, өвдөөгүй, эрүүл буюу яг нэг өөрийгөө аваад явж байгаа хүмүүсийн талаарх судалгаа энэ тэр чинь тэрүүгээр энүүгээр гарч ирэхгүй л дээ. Тэгэхээр тэрийг гаргахад энэ их чухал учраас энэ дээр зарчмын зөрүүтэй санал хамтарч гаргах хэрэгтэй байна аа. Энэ дээр бас хамтарч ажиллая гэж бодоод байна.

Б.Найдалаа: Энэ асуулт уу? Хариулт 2 номер.

Х.Сүрэнхорол: Сүрэнхорол. Мэдээж ажлын хэсгийн хүрээнд бол зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаад хэлэлцээд явах бүрэн боломжтой. Тэгээд гишүүдтэй хамтраад ажиллаад явъя.

Б.Найдалаа: Сая нөгөө Саранчулуун гишүүний саналтай холбоотой Чинбүрэн сайд дээр бид нар нэг амиа хорлохтой тэмцэх талаар нэг хэлэлцүүлэг хийгээд тэрний зөвлөмжийг Засгийн газар бид нар хүргэчихсэн байгаа манай Байнгын хорооноос. Тэгээд тэрэн дээр яг нэг салбарын асуудал биш салбар хоорондын олон яамд салбарууд хамтарч ажиллах ёстой ажил юм байна лээ. Тэрэн дээр нэг ажлын хэсэг ч юм уу нэг ийм нэг хөтөлбөр гаргая гэж ярьсан даа. Тэрэн дээрээ та нэг анхаараад өгөөрэй. Тэгээд Саранчулуун гишүүний саяын ярьж байгаа нь ер нь тэр юм байгаа юм.

Хосбаяр гишүүн асуулт асууна.

Б.Найдалаа: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ сургууль, цэцэрлэг, боловсролын салбар болон эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт маш чухал байгаа. Ирэх жил, ирэх 5 жилд боловсролын салбарт нэг улсын төсвөөр 1.2 их наяд, гадаадын зээл тусламжаар 460 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд энэ нэг 200, 300 сургууль цэцэрлэгээ барина л гэж төлөвлөж байх шиг байна. Тэгэхээр нөгөө хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах юм маань ер нь энэ дээр яг бодитой тусгагдсан дүн тоотой юм харагдахгүй байна л даа.

Тэгэхээр энэ дээр ер нь ямар төлөвлөлт хийж байгаа юм бэ гэж Эдийн засаг хөгжлийн яамнаас асуумаар байна. Сая Наранбаяр сайд хэлж байна. Би ч бас их санал солилцож байгаа. Ер нь хувийн хэвшилд маш их боломж байгаа. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, ер нь ямар ч барилга байгууламжийг Монголчууд барьж чаддаг болсон. Тэгээд хувийн хэвшлийнхээ энэ нөөц боломжийг ашиглаад уг нь жишээ нь боловсролын жил гээд зарлачихсан учраас бид нар энэ сургууль, цэцэрлэгийнхээ асуудлыг нэг дорвитой арга хэмжээ аваад бараг нэг жил, 2 жилийн дотор шийдчих ийм боломж уг нь байгаа л даа.

Тэгээд энэ дээр ер нь ийм боломж бололцоог Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам тооцож үзсэн үү? Тэгэхгүй бол бид нар чинь жил болгоны улсын төсөв дээр л нэг барилга байшин ярьсаар байгаад л нөгөө үндсэн бодлого үндсэн юмнууд ер нь ярихаа больчихлоо л доо. Дээр нь дахиад энэ олон сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга шинээр барихаас гадна дахиад энэ хуучин байгаа барилга байгууламжийн маань засвар арчлалт энэ юман дээр бас их хөрөнгө оруулалт

тавьж явж баймаар байна аа. Тэгэхгүй бол нэг шинэ байшин бариад тэрийгээ нэг мөнх настай юм шиг ингээд хаячихдаг. Тэгэнгүүт нөгөөдөх нь 1, 2 жилийн дараа манайх ямар байгаль цаг ууртай билээ. Ингээд элэгдэж хоргодоод дахиад өч төчнөөн шинээр барихаас наашгүй хэмжээний шахуу засвар арчлалтын зардал гардаг ийм зүйлүүд байна л даа. Тэгэхээр энэ чинь угаасаа норм дүрмээрээ барилгын тухай хуулиараа ч гэсэн засвар арчлалт дээр бас тодорхой хэмжээний мөнгө төгрөг тавьж шийдэж явах ёстой шүү дээ. Тэгэхээр ийм юмнууд дээр ер нь хэр зэрэг анхаарч байгаа вэ? Тэгээд энэ Боловсролын сайдад хэлэхэд энэ хувийн хэвшилтэй хамтарч ажиллавал хувийн хэвшилд маш их боломж байгаа, эрүүл мэндийн салбарт ч гэсэндээ бид нар нэг хавдрын 2 дугаар төв барина гээд 2 жилийн өмнө л ярьж эхэлсэн. Одоо дөнгөж зураг нь 70 хувийн гүйцэтгэлтэй гэж байна. 2028 онд барьж дуусгана гэж байна. Тэгээд улс юм хийхээрээ нэг ингэж удаан хийгээд байдаг. Гэтэл хувийн хэвшил бол өөрөө зураг төслөө боловсруулаад өөрсдөө хөрөнгө мөнгөө гаргаад ингээд нэг жил нэг жил хагасын дотор 2 жилийн дотор барьчихаад байна л даа. Тэгэхээр ер нь энэ нэг хувийн хэвшлийнхээ нөөц боломжийг л түлхүү ашиглаж энэ хөрөнгө оруулалтын асуудлаа нэг шийдээд явчихвал улсад ч тэгсэндээ бас нуруун дээрээс нь ачаа хөнгөлөгдөх юм байна гэж ингэж л харж байгаа. Тэгээд энэ дээр хариулт авъя.

Б.Найдалаа: Хариулт микрофон 4. Наранбаяр сайд.

Г.Хосбаяр: Баярлалаа. Хосбаяр гишүүний хөндөж ярьж байгаа энэ асуудлыг 100 хувь хүлээн зөвшөөрч байгаа. Энэ маш чухал. Тэгээд энэ чиглэл рүү бас энэ Эдийн засаг хөгжлийн яамтай хамтраад манай бас яамны зүгээс ажлын хэсэг байгуулаад энэ ажлыг эхлүүлэхээр ярилцаад явж байгаа. Тэгээд тодорхой бэрхшээлүүд түрүүн би дурдсанчлан урьд нь хэрэгжиж байсан концессын хууль нь төрд төсөвт маш их хэмжээний дарамт учруулсан гэсэн ийм нэг зүйл байдаг. Тухайн үедээ бас үнэлгээ тал дээр нь шударга тогтолцоо бүрэлдээгүй. Тэгээд төсөв дээр оруулж ирэхдээ бас нэлээн замбараагүй явсан ийм байдаг юм байна лээ. Гэхдээ цаг үе өөр болсон. Одоо бол манай хувийн хэвшил их хариуцлагатай, ил тод, компанийн засаглал сайтай болсон шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг бол бид шинэ түвшинд авч үзэх шаардлагатай гэж харж байна. Түүний зэрэгцээ татварын нэг хувийн хөнгөлөлтийг бас нэг сайн жишээнүүд үүсэж байгааг энд бас хэлье.

Нэгдүгээрт 1 хувийн хөнгөлөлтөөрөө багийн бага сургууль барьсан ААН-үүд байна. 4 газарт сая барилаа. НҮБ-ын Юнисеф буюу Хүүхдийн сангаар дамжуулаад. Ингээд манай урдаа барьдаг ААН-үүд болох энэ Монполимет, энэ Номин мөн Хаан банк гэх зэрэг ийм байгууллагууд оролцоод ингээд нэг хувийнхаа татварын хөнгөлөлтөөр сургуулиудыг шууд барьсан. Тэр нь ерөөсөө дулааны хэмнэлттэй яг тухайн орон нутгийнхаа онцлогт тохирсон ийм 2 давхар ийм барилгууд байгаа. Ийм хөөрхөн хөөрхөн ийм санаачилгууд гараад ингээд явж байгаа. Тэгэхээр хувийн хэвшлээр барихад зардал хэмнэх юм байна аа. Хувийн хэвшлээр барих юм бол бид нар хугацаа хэмнэх юм байна аа. Энэ бол яг хөдөлшгүй үнэн гэвэл үнэн. Тэгэхээр энэ чиглэл рүү бас эрх зүйн бололцоо юуг нь гаргаж ирээд төр хувийн хэвшлийн түншлэлээр яг энэ салбарт ерөөсөө л яриад байгаа тэр 108 сургууль, 95 цэцэрлэг одоо баригдаж байгаа энэ сургууль, цэцэрлэгүүдийг ингээд оруулаад энэ нэг ангид ноогдох хүүхдийн тоог 40-өөс доош байлгахад зориулсан энэ хэсэг рүү ингээд л хурдтай орчихмоор байгаа юм. Яагаад гэвэл өнөөдөр манайд хамгийн сайн өсөлттэй байгаа салбар барилгын салбар. Барилгын салбар нь хамгийн хурдтай хөгжиж байгаа юу гэвэл хурдтай хөгжиж байна.

Тэгэхээр яахаараа нэг сургуулийг 3 жил дамнуулж барьдаг юм. Яахаараа нэг сургууль тэр завсартаа 2, 3 дахин үнээ нэмж ингэж барьдаг юм энэ болохгүй байна. Ийм учраас тантай бас хамтраад бид бас энэ төр хувийн хэвшлийн түншлэлээр энэ асуудлыг шийдвэрлэх нь туйлын зүйтэй гэж үзэж байгаа болно оо. Түүний зэрэгцээ түрүүнд бас Саранчулуун гишүүн хөндөөд байна. Аз жаргалын индексийн асуудал. Энэ их чухал. Авлигагүй байх, байгаль орчин цэвэр байх, эдийн засгийн хувьд хүн амьдралын хувьд сэтгэл ханамжтай амьдрах энэ үзүүлэлт их чухал байдаг. Нолиос 10 балл хүртэл оноогоор хэмжээсжүүлдэг. Тэр дотор бас хөршийн харилцаа хүртэл явж байгаа шүү дээ. Хөршийн харилцаа сайтай, хөршүүдээ сайн мэддэг айл амьтан бие биеэ сайн тусалж ингэж орж гардаг ийм газруудад аз жаргал өндөр байна гэж. Тэгэхээр энэ индексийг бид бас оруулж ирж энэ төлөвлөлтүүддээ тусгах нь бас зүйтэй байна. 200 гаран орон хэрэглэж байна гэж байна шүү дээ энэ чинь.

Бас тэгээд цаана нь авлигын эсрэг байгаль орчин бохирдохын эсрэг, хүний эрхийн маш том мэдрэмжүүд, маш том үзүүлэлтүүд явж байгаа учраас зөвхөн мөнгөөр хэмждэг зөвхөн Жи Ди Пи-ээр хэмждэг ийм биш. Дэлхий нийтийн ийм хандлагыг бас Монгол Улс соргог хүлээж авах нь зүйтэй. Энэ чиглэлээр ч гэсэн манай салбарын зүгээс оруулах ямар индексийн үзүүлэлт байна саналаа өгөхөд бэлэн байна гэдгийг энэ дашрамд ашиглаад хэлье ээ. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Эдийн засаг, хөгжлийн яам микрофон 2.

Л.Сүрэнхорол: Эдийн засаг, хөгжлийн яам Сүрэнхорол.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудал бол Эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байдаг. Сая Төсвийн 2026 оны төсвийн тухай хуулийг дагаж Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд сая дагалдах хуулиудаар бас батлагдлаа. Төрийн хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль дээр бас нийгмийн үйлчилгээний дэд бүтцийн төслүүд буюу төрийн үйлчилгээний төслүүд дээр зарим тохиолдолд ТЭЗҮ шаардахгүй байх гэдэг бас онцлог зохицуулалт орж ирсэн. Энэ хууль маань бас батлагдсан. Энэ хүрээндээ бас Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай яг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар нийт 8 үе шатыг дамжиж, 12-оос 13 сарын хугацаа зарцуулж байгаа асуудал байгаа.

Тэгэхээр энийг бол бас батлагдсан хуулийн хүрээнд 4-өөс 8 шат дамжлагаар бууруулах эрх зүйн зохицуулалт нь бас батлагдаад явчихсан байгаа. Тэгэхээр төр хувийн хэвшлийн түншлэл маань илүү хэрэгжих боломжтой.

Б.Найдалаа: Хосбаяр гишүүн тодруулж асууна.

Г.Хосбаяр: Энэ дотуур байр бас нэг улсын хэмжээнд 83 дотуур байр барина гэсэн байна. Тэгэхээр хөдөө орон нутагт хөдөө суманд дотуур байр хамгийн чухал асуудал л даа. Хөдөөгийн малчин ард түмэн чинь нэг хүүхдээ сумын төв дээр аятай тохитой дотуур байранд байлгачхаад хичээл номыг нь хийлгээд тэгээд нөгөө мал хуйгаа хариулаад ажил амьдралаа зохицуулаад явахад таатай байх байх л даа. Тэгэхээр энэ дотуур байрны орчныг ер нь сайжруулах яах вэ бид нар нөгөө Эрдэнэтийн төслөөр бас нэг дотуур байр, сургуулийн нүхэн жорлонг устгах нэг төсөл бас хэрэгжүүлсэн. Тэр маань бас нэлээн амжилттай хэрэгжээд явж байгаа. Тэгэхээр энэн шиг ийм дотуур байран дээр дахиад тусгайлсан онцгойлон анхаарсан ийм

төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үү? Түрүүний дахиад миний нөгөө асуусан нэг хуучин сургууль, барилга байгууламжуудаа засвар арчлалт тал дээр нь ер нь яаж анхаарч ямар бодлого барьж явах юм бэ. Энэ дээр Наранбаяр сайд бас хариулт өгөөч.

Б.Найдалаа: Микрофон 4. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ дотуур байрны асуудал бас бид энэ ер нь дотуур байрыг бид нүхэн жорлонгоос нь бүрэн гаргаж байгаа. Эрдэнэтээс 170 тэрбум төгрөгөөр санхүүжүүлээд энэ ажил ингээд дуусаж байна. Хүндрэл үүссэн 20 гаран байршил байгаа. Тэрийг шийдчих ийм боломжтой гэж харж байна.

Хоёрдугаарт бас дотуур байран дахь хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, энэ чиглэлээр хөтөлбөр боловсруулаад санхүү төсвийг нь шийдэж өгөөд одоо энийг бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай Хүүхэд хамгааллын агентлагтайгаа хамтраад явахад бас боломжтой гэж харж байна. Мөн Эй Ди Би-ийн АХБ-ны шугамаар бас буцалтгүй тусламжийг хэрэгжүүлнэ. Түүний зэрэгцээ энэ дотуур байранд бас энэ ер нь цаашдаа ер нь эрэгтэй эмэгтэй хүүхдийг өөр өөр байранд байлгадаг байх, энэ хүүхдийн хамгааллыг илүү сайжруулах тэнд нь камержуулах гэх мэт иж бүрэн ажлуудыг хийж гүйцэтгэх ёстой гэж харж байгаа юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Нэмж тодруулна Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Чинбүрэн сайдаас бас асууя. Энэ нөгөө нэг танай салбарт ер нь энэ төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх боломжтой гэж харж байгаа юу? Ер нь гаднын өндөр хөгжилтэй орнууд чинь бас эмнэлэг энэ үйлчилгээ хөрөнгө нь дандаа л хувийн өмч бас байх шиг байгаа юм. Тэгэхтэйгээ зэрэг ер нь энэ ирээдүйд хийгдэх том том хэрэгцээ шаардлагатай энэ төвүүд энэ барилга байгууламж, хөрөнгө оруулалтын асуудлыг ер нь хувийн хэвшилтэйгээ хамтраад хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжээд явах уу? Энэ талаар ер нь ямар ажил яригдаж байгаа вэ? Тэгээд Эдийн засаг хөгжлийн яам бол ингээд нэг хуулийн л өөрчлөлтөө сая төсөв дагуулж оруулж ирсэн. Хийчихээр л бүх юм болчих юм шиг юм яриад л байгаа юм. Наад хууль чинь 2024 оны 1 сарын 1-нд хэрэгжиж эхэлснээс хойш нэг ч амж ажилтай хэрэгжсэн төсөл байхгүй байгаа шүү дээ. Тэгээд ийм хууль гаргачхаад энийгээ энэнд л нэг хэрэгжээд эхэлбэл болох байх. Нэг жоохон өөрчлөлт хийчихвэл болох байх гэж бас л харагдахгүй л байгаа даа.

Тэгэхээр ер нь их л том бодлогын дорвитой өөрчлөлт хийж жоохон хувийн хэвшилдээ итгэх хэрэгтэй байх л гэж бодож байна.

Б.Найдалаа: Хариултыг Чинбүрэн сайд микрофон 3.

Ж.Чинбүрэн: Ер нь зөв шүү энэ либералчлах аль болохоор төрөөс хамааралтай биш байдлаар тусламж үйлчилгээг хүргэдэг байх бодлого ЭМЯ-ны бас нэг том бодлогын зорилго. Жишээлбэл 2020 оны 8 сард хийсэн ЭМД-ын цогц шинэчлэлийн хүрээнд ер нь гол үзэл санаа нь бол улс болон хувийн эмнэлгийн ялгааг арилгах том зорилго хийсэн шүү дээ. Санхүүжилт нь улс, хувийн эмнэлэгт хуучин бол 80, 20-ийн харьцаатай. Жишээлбэл улсын эмнэлэг тусламж үйлчилгээ үзүүлсэн бол 80 хувийн санхүүжилтийг даатгалаас өгөөд хувийн эмнэлэгт үзүүлсэн бол 20 хувийг нь өгдөг байсныг болиод ямар нэгэн ялгаагүй болгож өгсөн. Энэ бол ерөөсөө том шинэчлэл байсан.

Харамсалтай нь бид энэ даатгалын тогтолцоо маань санхүүжилттэй төлөвлөлт өртгийн жинг бодитой тооцож чадахгүй байгаа учраас гүйцэтгэлээр авсан санхүүжилт нь тухайн байгууллагын оршин тогтнох эс үгүй бол хөрөнгө оруулсан хөрөнгөө нөхөх боломжийг олгож чадахгүй байгаад байгаа юм.

Тийм учраас бид энэ 2026 онд хэрэгжүүлэх гэж байгаа энэ даатгалын тогтолцооны цогц реформ бол энэ өртгийн жинг зөв тооцдог болох.

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Микрофон 3.

Ж.Чинбүрэн: Гүйцэтгэлээр авсан санхүүжилт нь тоног төхөөрөмж цалин пүнлүү дээрээс нь хөрөнгө оруулалтаа нөхөх ийм хэмжээнд болгох ийм том алхмыг хийх зорьж байгаа. Ер нь цаашдаа энэ чиглэлээр явна шүү. Ер нь эрүүл мэндийн салбар заавал төрийн эмнэлгүүд гээд л баахан төвлөрсөн баахан ийм буруу тогтолцоог бид дэмжих биш. Илүү либералчлах нь чухал. Тэгэхдээ энийгээ юун дээр либералчлах вэ аль түвшинд. Жишээлэх юм бол аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшнээс доошоо хэмжээнд бол бид либералчлахад ерөөсөө болохгүй юм байхгүй. Улсын том үндэсний төвүүд дээр бол асар их хөрөнгө оруулалт ордог.

Жишээлбэл эмчилгээ нь цорын ганц Монгол Улсад байдаг. Жишээлбэл туяа эмчилгээ гээд л аваад үз. Санхүүжилт нь нэг машин нь гэхэд л 3 сая доллароос дээш үнэтэй өртөгтэй. Ингээд сервис нь асар их зардалтай. Энийг хувийн хэвшлийнхэн аваад явахад өртөг зардлаа нөхөх боломж нь одоогоор хангагдаж чадаагүй байгаа учраас төр дэмжихээс өөр аргагүй ийм бодлогууд явж байна. Тэгээд аажимдаа энэ бол өртгийн.

Б.Найдалаа: Баярлалаа. Гишүүд асуулт тавьж, хариулт авч дууслаа.

Одоо Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал бүр дээр санал хураалт явуулах юм аа. Үг байхгүй. Зөвхөн зарчмын зөрүүтэй саналыг гаргасан гишүүд тайлбар хэлнэ. Эсвэл холбогдох албан тушаалтан тайлбар хэлнэ ээ.

Тогтоолын төсөлтэй холбоотой зарчмын хувьд санал зарчмын зөрүүтэй саналуудыг би нэг бүрчлэн уншаад танилцуулаад явъя.

Нэг.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралттай холбоотой санал:

1.Төслийн 1 дүгээр хавсралтын “Хүний хөгжил” бодлогын чиглэлд доор дурдсан агуулгатай 1.3 дахь заалт нэмэх:

“1.3.Улсын хөгжлийн тэргүүлэх салбар болсон боловсролын салбарын санхүүжилтийг хүртээмжтэй, тогтвортой өсгөх зорилгоор жил бүр тухайн жилийн Төсвийн тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тооцоолсон дотоодын нийт бүтээгдэхүүний зургаагаас доошгүй хувийг, эсхүл улсын төсвийн нийт зардлын хориос доошгүй хувийг боловсролын салбарт зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Мөнхтуяа гишүүн энэтэй холбоотой нэмэлт тайлбар хэлж болно. Мөнхтуяа гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бид бол маш олон жилийн хугацаанд энэ боловсролын салбарын тулгамдаж байгаа асуудлын талаар шүгэл үлээж зохих түвшнийх нь байгууллагад шаардлага хүргүүлсээр ирсэн. Ер нь манай боловсролын салбарын багш ажилчдын нийгмийн баталгаа маш хүнд, цалин хөлс бага. Сая гэхэд л багш нар, эмч нар ажил хаясан. Мөн энэ ахмадууд зогсож байгаа. Энэ бүхэн маань энэ санхүүгийн асуудалтай холбогдож л ер нь нийгмийн баталгаагаа дээшлүүлэх гэж л хүмүүс тэмцэж байна шүү дээ. Тэрнээс өөр юм бол төр засгаас шаардаагүй. Тэгэхээр хамгийн чухал юм бол бид нар жил болгон 5 жилийн төлөвлөгөө гээд л нэг юм зүгээр тунхаг төдий юм гаргаад тэгээд тэрийгээ хэрэгжүүлэх ямар ч тийм шалгуур үзүүлэлтгүй юм гаргадаг. Энэ жил харин шалгуур үзүүлэлт бас дөхөм юмнууд оруулсан сайшаалтай байна.

Тэгээд дээрээс нь нэмээд хэлэхэд ер нь энэ багш нарын цалин улсын төсвийн зардлын хэдэн хувьтай байх ёстой юм бэ гэдгийг бүүр нэмж оруулах шаардлага байгаа. Бид нар өнөөдөр энд зүгээр багш нарын нийгмийн баталгааг хангана гээд л орхичхож байгаа байхгүй юу. Яаж хангах юм ямар түвшинд аваачих юм гэдэг нь тодорхой бус байгаа. Тийм учраас миний энэ оруулж байгаа зарчмын зөрөөтэй санал бол багш нарын цалин хөлс нийгмийн баталгаа бол улсын төсвийн зардлын 20 хувиас багагүй, ДНБ-ий 6 хувиас багагүй түвшинд байх ёстой гэдгийг шалгуур үзүүлэлтэд нь оруулж тодорхой болгож өгье өө. Тэгэхгүй бол жил бүр цалин нэмье гээд ингээд багш ажилчид нь босоод ирдэг. Тэгээд нөгөө Засгийн газар сайд нар нь хоорондоо хөлөө жийлцэнэ, хэрэлдэнэ. Бөөн асуудал үүссэн шүү дээ сая бол.

Тэгэхээр энийг хэрүүлгүй, уруулгүй яг энэ тодорхой түвшинд нь бариад улсын төсвийн юун дээр нь нэмэхгүйгээр дотоод дотор нь төсвийн хуваарилалт хийгээд боломж бид нарт байгаа гэдгийг сая бас харууллаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр одоо яг энэ зарчмын зөрүүтэй саналыг баталж чадах юм бол бид нар жил бүр энэ багшийн цалинтай холбоотой асуудлаар хэрүүл уруул маргаангүй болно оо. Маргааныг ингээд эцэслэе ээ. Жил бүр л багшийн цалин өндөр байх ёстой боловсрол 1 дүгээрт байх ёстой гээд л нэг тунхаг яриад байдаг мөртөө яг үнэхээр хачир дээрээ барих ямар ч тийм баримт бичиг байхгүй. Зүгээр л тэгнэ ингэнэ гээд ирээдүй цаг дээр бичээд л орхичихдог. Тэр нь тэгээд хэрэгжсэн ч юм байхгүй тэгээд л дараа жил нь дахиад л бөөн хэрүүл үүсдэг.

Тэгэхээр энэ хэрүүлд одоо өнөөдөр бид нар зүгээр ярьж суухынхаа оронд хийе. Зоригтой алхам хийе гэдэг үүднээс энэ зарчмын зөрүүтэй саналыг оруулж байгаа. Тийм учраас манай энэ Байнгын хорооны гишүүд маань бас боловсролын салбартаа хайртай хүмүүс байгаа байх. Дэмжиж өгөөрэй гэдгийг бас хүсмээр байна аа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа энэ саналтай холбоотой тодруулах юм гарна гарч байна. Тэгэхээр энэ Сангийн яамнаас болон яамдуудаас яг гол хүн хэн байна тэр микрофон дээр суучихмаар байна. Сангийн яамнаас хэн байгаа вэ? Эдийн засаг, хөгжлийн яамнаас тийшээ микрофон руу суучих. Дугаартай микрофон руу. Соёлын яам, төрийн нарийн яг гол төлөөлж байгаа хүн тэр микрофон дээр суучихмаар байна.

Жишээлбэл яг саяын саналтай холбоотой Сангийн яамнаас энэ төсөвтэй холбоотой яг ямар зарчим баримталж байгаа юм. Ингээд шийдвэл асуудал байгаа юу, байхгүй юу, зөв юм уу, буруу юм уу санал сонсьё. Микрофон.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя Сангийн яам Дэлгэржаргал.

Төсвийн нийт зардал дээр ингээд хувь тогтоох асуудал дээр жишээ нь хөрөнгө оруулалтын зардал бол хэрэгцээ шаардлагаараа тавигддаг. Тогтмол зардал бол биш. Өөрөөр хэлбэл хаана сургууль хэрэгтэй байна, хаана хөрөнгө оруулалт хийх вэ гээд төсвийн хөрөнгө оруулалт өөрөө урсгал зардлыг бодвол тогтмол зардал биш хэрэгцээ, шаардлага, шалгуурууд үзүүлэлт маш олон зүйлээс авч ингэж тухайн жилдээ тавигддаг. Тэгэхээр тогтмол хувь заах нь өөрөө бас эрсдэлтэй байх болов уу гэж бодож байна. Урсгал зардлын хувьд бол яг Боловсролын яам энэ дээр илүү яг урсгал зардлынхаа асуудлыг хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Б.Найдалаа: Боловсролын яамнаас хүн байгаа юм уу? Дээшээ микрофон руу. 5 дугаар микрофон дээр. микрофон 5.

Б.Алимаа: Энийг манай сайдын багц 2026 онд ДНБ-ий 5 хувь ба улсын төсвийн нийт зарлагын 16 хувийг эзэлж байгаа. Энийг яг 6 хувь 20 хувьд хүргэхийг бол манай яам мэдэхгүй. Сая нөгөө нэг багш нарын хэлэлцээртэй холбоотойгоор хэлэлцээрийн юунд 6 хувь 20 хувьд хүргэе гэдэг саналыг оруулсан. Энийг бол Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам мэдэж хариулах байх аа.

Б.Найдалаа: Гишүүд ямар ч байсан санал хураасан гишүүнээс мэдээлэл авсан. Сангийн яам болон Боловсролын яамны хариултыг сонслоо. Тэгээд энийг бид нар санал хураагаад шийдэх ёстой санал. Хураалтад бэлдье.

Мөнхтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 52.9 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганын “Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах” гэснийг “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж, “Хамтран хариуцагч” баганын “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэснийг “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж өөрчлөх.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтад доор дурдсан агуулгатай шалгуур үзүүлэлтийн мөр нэмэх:

“1.1.1.1. “Шалгуур үзүүлэлт” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно, “ТХЗ уялдаа” 4.с.1, “Хэмжих нэгж” Индекс, “Суурь түвшин” Он 2024, Түвшин 2,332.4 (мян.төг), “Зорилтот түвшин” 2026 он 2025 оны түвшнээс дээгүүр, 2027 он 2026 оны түвшнээс дээгүүр, 2028 он 2027 оны түвшнээс

дээгүүр, **2029 он** 2028 оны түвшнээс дээгүүр, **2030 он** 2029 оны түвшнээс дээгүүр, “Мэдээллийн эх сурвалж” Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, “Мэдээлэл цуглуулах арга зүй” Статистик тоон мэдээлэл, салбарын тайлан, “Мэдээлэл цуглуулах давтамж” Жил тутам, “Хариуцах байгууллага” Боловсролын яам.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Мөнхтуяа гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнхтуяа: Эхний саналыг дэмжиж өгсөн Байнгын хорооны гишүүддээ маш их баярлалаа. Тэгээд энэ дээр нөгөө улсын төсвийн нөгөө нэрлэсэн тоо байгаа шүү дээ. Одоо статистик жил бүр нөгөө Статистикийн хорооноос улсын дундаж цалин нэрлээд гаргачихдаг юм шүү дээ 2 сая 700 ч гэх юм уу тиймээ. Тэгвэл энэ бас нэрлэсэн цалингаас дээгүүр байна гэдэг заалтыг оруулж өгч тодорхой болгож байгаа юм. Одоо ер нь бол бид нар боловсрол тэргүүлэх салбараа. Улс орны тэргүүлэх салбар гэххээд өнөөдөр багш нар нь улны цалин аваад л явж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ сая 400 мянган төгрөгийн цалин бол багш нарын амьдралд хаана нь ч хүрдэггүй цалин. Өрнөөс өрний оронд л амьдарч байгаа. Тийм учраас энэ багш нарын цалин нийгмийн баталгааг тодорхой тоо тавьж байж л юу яахгүй бол зүгээр л нийгмийн баталгааг дээшлүүлнэ ээ.

Яаж дээшлүүлэх юм, хэдэн хувиар дээшлүүлэх юм байхгүй. Тэгсэн мөртөө улсын нэрлэсэн дундаж цалин гээд ингээд статистик гаргаад байна шүү дээ. Тэгэхээр ер нь багш нар улсын нэрлэсэн дундаж цалингаас дээгүүр цалин авч байж бас нэг тодорхой түвшинд нийгмийн баталгаа нь хангагдана гэж үзсэний үндсэн дээр энийг оруулж ирж байгаа юм шүү гэдгийг бас хэлье ээ. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа энэнтэй холбоотой бас яг Сангийн яамнаас тодруулга авна аа. Микрофон 6.

дундаж цалинг яаж тооцдог юм, тэгээд энэ боломжтой юм уу ингээд тогтоочиход болж байгаа юм уу?

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад Сангийн яам Дэлгэржаргал. Би Санжаадорж дарга руу хэлчихлээ. Одоо дотор явж байгаа ороод ирье гэж байна. Цалингийн асуудал дээр тэндээс илүү хэлэх нь зүйтэй болов уу. Би бол хөрөнгө оруулалтын асуудал хариуцдаг учраас яг тодорхой хэлэх боломжгүй байна.

Б.Найдалаа: 3 микрофон 3-ыг Хөдөлмөр нийгмийн хамгаалал чинь яг хэн билээ? Микрофон нэг дээр суугаад нэг асуулт байна. Улсын дундаж цалинг яаж тооцдог юм. Тэрэнд багш нарын цалингийн хэмжээ хэр жинтэй оролцдог юм? Хэрвээ жинтэй оролцдог бол энэ чинь хоорондоо холбоо хамааралтай ийм тооцооллын юутай болох гээд байгаа байхгүй юу. Микрофон 1.

Б.Алимаа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны газрын дарга Алимаа гишүүний асуултад тодруулга өгье өө. Улсын дундаж цалинг Үндэсний статистикийн хороо улирал бүр тооцож байгаа. Мэдээллийн эх үүсвэр нь НДЕГ-ын нийгмийн даатгалын даатгуулагчдын мэдээллийн сангаас цалин хөлснийх нь мэдээллийг авч дунджилж ингэж нэрлэсэн цалингаа гаргаж тооцож байгаа. Тэгэхээр энэ бол нөгөө НДШ төлөгчдийн авч байгаа цалингийн дунджаас гарч байгаа гэдэг тэгээд 1 сая орчим даатгуулагчийн мэдээллийн сангаас гаргаж байгаа. Тэгэхээр энэ

багш нар үндсэндээ албан секторт хамрагдаж байгаа учраас бүхэлдээ энэ нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазад байж байгаа.

Б.Найдалаа: Дотор нь ордог гэсэн үг тийм үү.

Б.Алимаа: Орно гэсэн үг.

Б.Найдалаа: Хэдэн багш байдаг билээ?

Б.Алимаа: Яг багш нарын тухайд бол нийтдээ боловсролын салбарт 93 мянга орчим багш албан хаагч нар.

Б.Найдалаа: 10 орчим байгаа юм уу?

Б.Алимаа: Тийм багш нар 40 гаруй мянган албан хаагч нар байгаа.

Б.Найдалаа: Ойлголоо хариулт авч дууслаа. Зарим Сангийн яамнаас хэрвээ ирээгүй бол хариулт байхгүй гэсэн үг. Мөнхтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Нийт гишүүдийн санал хураалтад оруулсан гишүүдийн 58.8 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Арга зам” баганын “Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах” гэснийг “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж өөрчилж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж нэмэх.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтад доор дурдсан агуулгатай шалгуур үзүүлэлтийн мөр нэмэх:

“1.1.2.2. “Шалгуур үзүүлэлт” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно, “ТХЗ уялдаа” 4.с.1, “Хэмжих нэгж” Индекс, “Суурь түвшин” **Он 2024, Түвшин 2,332.4** (мян.төг), “Зорилтот түвшин” **2026 он 2025 оны түвшнээс дээгүүр, 2027 он 2026 оны түвшнээс дээгүүр, 2028 он 2027 оны түвшнээс дээгүүр, 2029 он 2028 оны түвшнээс дээгүүр, 2030 он 2029 оны түвшнээс дээгүүр**, “Мэдээллийн эх сурвалж” Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, “Мэдээлэл цуглуулах арга зүй” Статистик тоон мэдээлэл, салбарын тайлан, “Мэдээлэл цуглуулах давтамж” Жил тутам, “Хариуцах байгууллага” Боловсролын яам.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Мөнхтуяа гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнхтуяа: Манай Монгол Улс бол олон улсын өмнө боловсролынхоо салбарт ийм хөрөнгө оруулалт оруулна гэсэн ийм бүүр тодорхой үүрэг амлалт авчихсан шүү дээ. Тэр нь юу вэ гэхээрээ 2015 онд дэлхийн Боловсролын сайд нарын уулзалт, чуулга уулзалт Инчон хотод болсон. Инчоны тунхаглал гэж гаргасан. Энэ тунхаглал дээр бол боловсролд улсын төсвийн нийт зардлын 20-оос доошгүй хувийг

ДНБ-ий 7 хувь гэж байгаа. Тэгэхээр бид нар энэ олон улсын гэрээ, конвенц, тунхаглалд гарын үсэг зураад үүрэг хүлээчхээд өнөөдөр одоо тэрнээс хойш 10 гаруй жил өнгөрчихсөн байхад ямар ч тийм нэмэгдсэн болж байгаа юм байхгүй бөөн асуудал тийм ээ.

Тэгэхээр энэн дээр бид нар яг нэг зоригтой алхам хийх цаг нь болчихсон. Тийм учраас энэ 2030 онд Инчоны тунхаглал гэрээндээ одоо дүгнэлтээ хийнэ ээ. Дүнгээ тавина. Тэгээд энэ манай улс дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 4 хувьтай, улсын төсвийн зардлын 13 хувьтай л байгаа шүү дээ ер нь бол. Гадаадын зээл тусламжаар АХБ-ны зээлээ оруулаад арай гэж нэг 5 руу орж байгаа шүү дээ. Бодит үнэн энэ. Бид нар ингээд хаа хамаагүй энд тэндээс авсан зээлээ хүртэл оруулаад ингэж тоогоо нэмж худлаа ярьдгаа болих хэрэгтэй.

АХБ-ны 150 сая доллар чинь энэ ДНБ-ий 5.3 руу гэж яриад байгаа байхгүй юу. Улсын төсвийн зардлын 16 хувь хүрчихсэн байгаа гээд байгаа юм. Тэгээд багш ажилчдын цалин хөлс нь тэр доор байхад яагаад ч хүрэх боломжгүй.

Тэгэхээр энийг яг бодитойгоор нь гаргаж ирэх хэрэгтэй 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ Сангийн яамнаас хүн байхгүй ийм утгагүй байж болохгүй шүү дээ тиймээ. Зарчмын зөрүүтэй санал оруулж байхад чинь мэдэх хүнгүй гээд сууж байдаг. Үнэхээр хариуцлагагүй байна. Тэгээд яг шаардлагатай бид нарын энэ хэлэлцэж байгаа үед нь байхгүй байсан байж дараа нь тэр ч болохгүй энэ ч болохгүй гээд баахан хаалт яриад суудаг ийм зарчимгүй байж болохгүй ээ.

Тийм учраас энэ Сангийн яамны тэр төрийн нарийн юу байдгийг нь яг мэдэх хэмжээнийх нь хүн нь суумаар байна аа. Одоо тэгээд л багш нарын цалинг нэмэх ёстой гээд та нар сонгуулийн манай Их Хурлын гишүүд сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөр, тэр иргэдтэй уулзах уулзалт бүгд дээр нь л ярьдаг юм шүү дээ. Багшийн цалин мянган доллар байх ёстой гээд. Тэгээд цалинг нь нэмье ингээд яг бодлогоо гаргаад бүгдээрээ ярилцаад сууя гэхээр ингээд худлаа алга болчихдог. Битгий ийм жүжгийн бай л гэж хэлмээр байна. Би ер нь хатуухан хэлмээр байна.

Б.Найдалаа: Баярлалаа юу. Тайлбар түрүүний агуулга нь ойролцоо байсан учраас шаардлагагүй гэж бодож байна. Яг түрүүний заалттай ижил агуулгатай зүйл байгаа юм. Тайлбар хийх хүн байхгүй шүү дээ. Ямар ч байсан санал гаргасан гишүүн тайлбараа хэллээ. Түрүүн бид нар бас яг тайлбар сонссон. Тэгээд яг байгаа мэдээлэл дээрээ дэгийнхээ дагуу саналаа хураагаад явъя.

Саяын Мөнхтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 52.9 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал Төслийн 2 дугаар хавсралтын (Бодлогын зорилго): 1 “Хүний хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ” бүлгийн “1.1.Боловсролын чанар хүртээмжийг сайжруулна” хэсэгт доор дурдсан агуулгатай 1.1.3.4 дэх дэд заалт нэмэх:

“1.1.3.4.“Бодлогын үндэслэл” АХ-2.1.34, “Салбар /ТЕЗ/ Хөтөлбөрийн нэр” 71804 Мэргэжлийн боловсрол, “Үр дүн” Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна, “Арга зам” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас

дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах, “Үндсэн хариуцагч” Боловсролын яам, “Хамтран хариуцагч” Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам”.

Төслийн 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 1.1.3.4 дэх дэд заалт нэмэх:

“1.1.3.4. “Шалгуур үзүүлэлт” Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно, “ТХЗ уялдаа” 4.с.1, “Хэмжих нэгж” Индекс, “Суурь түвшин” **Он 2024, Түвшин 2,332.4** (мян.төг), “Зорилтот түвшин” **2026 он 2025 оны түвшнээс дээгүүр, 2027 он 2026 оны түвшнээс дээгүүр, 2028 он 2027 оны түвшнээс дээгүүр, 2029 он 2028 оны түвшнээс дээгүүр, 2030 он 2029 оны түвшнээс дээгүүр, “Мэдээллийн эх сурвалж” Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, “Мэдээлэл цуглуулах арга зүй” Статистик тоон мэдээлэл, салбарын тайлан, “Мэдээлэл цуглуулах давтамж” Жил тутам, “Хариуцах байгууллага” Боловсролын яам.** Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Мөнхтуяа гишүүний микрофоныг нээе.

Б.Найдалаа: Энд ингээд адилхан тус тусдаа яваад байгаа шүү гишүүд ээ. Юу вэ гэхээр нөгөө СӨБ, тэгээд ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол гээд ийм 3 тусдаа явж байгаа шүү наад юунууд чинь саналууд чинь.

Мөнхтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал гаргасан гишүүдийн 41.2 хувь дэмжиж санал дэмжигдсэнгүй ээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн 4.2.4.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Авьяасыг тасралтгүй хөгжүүлэх” гэсний дараа “хичээлийн дараах хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа. Пунсалмаа гишүүн байгаа юу? Байхгүй байна. Пунсалмаа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 52.9 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтын “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /нийслэл/” мөрний “Суурь түвшин” баганын Түвшин: “76.5” гэснийг “Т* /*Бодитоор тооцох/” гэж, “Зорилтот түвшин” баганын 2026: “78” гэснийг “Т+2 хувь” гэж, 2027: “80” гэснийг “Т+4 хувь” гэж, 2028: “82” гэснийг “Т+6 хувь” гэж, 2029: “84” гэснийг “Т+8 хувь” гэж, 2030: “88” гэснийг “Т+10 хувь” гэж, мөн дэд заалтын “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /аймаг/” мөрний “Суурь түвшин” баганын Түвшин: “97” гэснийг “Т* /*Бодитоор тооцох/” гэж, “Зорилтот түвшин” баганын 2026: “98” гэснийг “Т+2 хувь” гэж, 2027: “99” гэснийг “Т+4

хувь” гэж, 2028: “99” гэснийг “Т+6 хувь” гэж, 2029: “99.5” гэснийг “Т+8 хувь” гэж, 2030: “99.9” гэснийг “Т+10 хувь” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах.

Галбадрах гишүүний микрофоныг нээе. Би түрүүнээс хойш хэлээд байгаа. Энэ бүгдээрээ энэ суурь түвшнээ их бодитой тогтоох ёстой гээд. Тэгээд би энэ дээр суурь түвшнийг 76.5. Одоо энэ асуулт нь юу гэж байгаа вэ гэвэл стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь гээд гаргаад ирсэн байгаа юм.

Тэгэхээр Монгол Улс өнөөдөр 704 сургуультай. 704 сургуульд нь 23778, энэ өнгөрсөн хичээлийн жилд авсан тоо шүү. Энэ жил яах вэ бүлэг нэмэгдлээ гэхэд 100 дотор нэмэгддэг юм байна лээ. Нэмэгдлээ хасагдлаа гэхэд. Энэ дотроос нь 40-өөс дээшхийг нь аваад үзэхэд 40-өөс дээш хүүхэдтэй бүлгийг аваад үзэхэд 4860, 35-аас дээш гээд аваад үзэхээр 9127, бүүр 30-аас дээш стандарт хангана гэдэг БХБЯ-ны ЕБС-ийн барилгын төлөвлөлтийн тийм норм дүрэмд нь 30-аас бага байх сурагчтай байхаар төлөвлөнө өө гэхихсэн байж байгаа. Тэгээд 30-аас багыг нь оруулаад ирэх юм бол бүүр 13773 бүлэг буюу нөгөө 23778 бүлэг дотроо 57.9 хувь. Энэ нь нөгөө дээших нь.

Тэгэхээр энэ энийгээ хасаад үзэхээр стандарт хангасан буюу 30-аас дооших нь 42-хон хувь болчихоод байгаа юм. Тэгтэл 42 хувийг өнөөдөр 76.5 хувь гээд ингээд бичиж байгаа нь энийгээ бодох ёстой юм байна гээд. Тэр суурь түвшин гэдгийгээ Т гэж оруулж ирээд тэгээд энийгээ 90 хувь хүргэнэ 76 байж байгаагаа стандарт хангасан сургуулийг 90 хувь хүргэнэ гэсэн. Бид нар энэ стандарт хангах тухай асуудлыг 20 жил яриад байгаа мөртөө хэдэн хувиар ингээд бүүр муудаад яваад байгаа болохоос биш юу руугаа ингээд яваад байгаа шүү дээ.

Тэгэхээр энийгээ их бодитой тавих ёстой юм гээд тэр хувийг нь яах вэ жилдээ нэг 2 хувь, 3 хувиар ингээд нэмээд явбал гэсэн үүднээс тавьсан шүү. Тэгэхээр ийм бодитой дүгнээ гэдэг үүднээс байгаа. Тэгээд одоо цаашдаа ажлын хэсэг, би сая Боловсролын яам энэ тэртэй бас ярилаа. Энэ тоонуудаа гаргаж ирээд нарийн тавиад яваасай гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал. Харин нэмэгдүүлж явахыг хэд гэж тогтоох вэ? Ямар ч байсан 76.5 бол худлаа тоо байна шүү гэдгийг л энүүгээр хэлж байна.

Тэгэхээр тэр суурь тоогоо гаргаж ирээрэй. Тэгээд тэрэн дээрээ хүрэх үр дүнгээ ингээд бодитоор нөгөө 108 сургууль, 95 цэцэрлэг гээд. Цэцэрлэг дээр бас яг адилхан ийм тоо яваад байгаа. Тэгэхээр энийгээ засах хэрэгтэй. Одоо бас ажлын хэсэг шинээр байгуулагдаад энэ Тэмүүлэн гишүүн ахалж байгаа юм шиг байна. Энэ хуралдах гэж байна. Энэ дээр ингээд засаад явах нь зүйтэй гэдэг үүднээс гаргасан санал.

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ стандарт хангах тухай зүй чухал санал байна. Тэгээд энэ дээр бол ойлгомжтой учраас тайлбар шаардлагагүй гэж бодож байна аа. Ийм учраас Галбадрах гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Нийт гишүүдийн 66.7 хувь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь” гэсэн мөрний “Зорилтот түвшин” баганын 2027: “36” гэснийг “32” гэж, 2028: “51” гэснийг “40” гэж, 2029: “71” гэснийг “50” гэж, 2030: “96” гэснийг “65” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах. Галбадрах гишүүний микрофоныг нээе.

Ж.Галбадрах: Энэ дээр болохоор нөгөө Суурь түвшин түрүүнийх ингээд худлаа байна. Тооцоо муу байсан гэсэн бол энэ хүрэх зорилтот түвшин нь энэ хэт өөдрөг гэх юм уу маш их явсаар байгаад бүүр наян хэдэн 96 хувьд хүргэнэ гээд байгаа 2030 онд. Одоо яг суурь түвшнээ бид нар эргээд хараад үзэхээр чинь энэ чинь ерөөсөө 23 хувьтай л байж байна шүү дээ. Суурь түвшин маань. Тэгээд байгаа энэ тоог яаж энэ тавхан жилийн дотор бид нар 96 хувьд хүргэх билээ гэдэг энийгээ бодох ёстой. Тэгээд өнөөдрийн байдлаар би ингээд багшийн судалгааг ингээд хийж үзсэн хүн байгаа юм. Багшийн судалгааг хийгээд үзэхэд ерөөсөө 100 хувийн дүүргэлттэй сургууль ерөөсөө л 22.5. Энэ нь бол нөгөө 23 хувь гэдэгтэй маань таарч байгаа. Тэгээд өнөөдөр бид нар багшаа яаж бэлдээд байгаа билээ?

Тэгж их олноор нь ингээд сургаад багш мэргэжлээр сурч байгаа хүмүүс байгаа билүү? Багшийгаа яаж ирэхээр нь нөгөө 77 хувь дутуу байсныгаа эргээгээд бид нар бүүр 23 хувиа яаж 96 хувь болгох юм гэдэг энэ асуудал нь тодорхой. Би энэ дээр бас Боловсролын яамнаас бас хариулт сонсмоор байна. Ямар төлөвлөгөө хийчихсэн учраас та бүхэн маань ийм 96 гэдгийг нь 5 жилд хийчхэв ээ. Тэгвэл их амархан бид нар чинь ингээд л багшаа гүйцээчих байсан юм биш үү. Би энийг бодитоор бид нар 30 он гэхэд нэг 65 хувьдаа хүргэвэл их болох юм байна гэдэг ийм бодит юм тавихгүй бол энэ чинь нөгөө эргээд төлөвлөлтөө бид нар дүгнээд явахаар биеллээгүй биеллээгүй гэдэг юм руугаа ороод яваад байх юм уу л гэдэг үүднээсээ санал гаргасан. Тэгэхдээ би энийг бас хий хоосон тоо тавиагүй. Яг тооцооллоор МУБИС-д сурч байгаа одоо багш бэлтгэж байгаа сургуулиас хэдэн хувь нь багшаараа ажиллаад байгаа юм? Энэхүү бүх тоог нь магадлалаар бодож байгаад бас тэгэхдээ бол энийгээ би өөрөө 100 хувь тэр өсөлтийг нь гаргахгүй. Мэдээж мэргэжлийн байгууллага Боловсролын яам өөрөө энэ дээрээ маш сайн суух хэрэгтэй байна. Маш сайн тооцоолол хийх хэрэгтэй байна гэсэн үндэс байна.

Тэгээд яагаад 96 хувьд хүргэнэ гэсэн юм бэ гэдгийг нь асуух гэсэн юм.

Б.Найдалаа: Баярлалаа. Яах вэ дэгээрээ бол энэ бол асуулт хариулт авахгүй. Гэхдээ ямар өнцгөөс Боловсролын яамнаас нэг юм тодруулж байгаа бол ингэж асууна. Яг энэ өөрчлөлтийг хийхийг татгалзах зүйл байгаа юу? Болохгүй юм юу байна тэрийгээ л хэлчих Боловсролын яам хэн байгаа юм. Микрофон 5.

Бадамжав: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Бадамжав. Гишүүний энэ санал дээр бол татгалзах зүйлгүй. Гишүүнтэй хамтарч ажиллаад үзүүлэлтээ гаргаж болно. Гэхдээ зүгээр энэ яах вэ 19 цагийн нормативаараа тооцсон. Мэргэжлийн багшийн хангалт бол ерэн хэдэн хувьтай байгаад байгаа. Яг мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан гээд 19 цагийн нормоороо тооцохлоор ингээд 20 хэдэн хувьтай гаргаад байгаа. Энэ хүрээнд яагаад 96 хувь гэсэн бэ гэхлээрээ зэрэг багшийн талаар баримтлах 3 тулгуурт бодлогыг хэрэгжүүлсний үр

дүнд энд хүрнэ гэдэг зорилт тавьсан. Гэхдээ гишүүний саналыг хүлээж аваад хамтарч ажиллана аа.

Б.Найдалаа: Баярлалаа дэмжиж байгаа юм байна. Галбадрах гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Хосбаяр гишүүн. Хосбаяр гишүүний микрофоныг нээе.

Г.Хосбаяр: Уучлаарай. Би нөгөө босож тэнд нэг асуулт асууж явж байгаад саналаа өгч чадсангүй. Тэгэхээр дахин санал хураалт явуулж өгөөч.

Б.Найдалаа: Хосбаяр гишүүний гаргасан саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

Гишүүдийн 61.1 хувь нь дэмжиж, саяын санал хүчингүйд тооцлоо. Одоо Галбадрах гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Мөнхтуяа гишүүн саналаа өгөөч. Гишүүдийн 66.7 хувь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал

Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

Төслийн **2 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “1.2.1.7” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.2.5” гэж, “Салбар” баганад “71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ” гэж, “Үр дүн” баганад “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, “Арга зам” баганад “Үзлэг, оношилгоо, шинжилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам” гэж; **3 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “1.2.1.7” гэж, “Салбар” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, “Үр дүн” баганад “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг тогтмолжуулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүн ам” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+3%, 2027: Т+5%, 2028: Т+8%, 2029: Т+10%, 2030: Т+15%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам” гэж.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл.

Мөнхсоёл гишүүн байна уу. Байхгүй байна.

Мөнхсоёл гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 55.6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай дэд заалт нэмэх:

Төслийн **2 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.7” гэж, “Салбар” баганад “72212 Гэр бүлийн хөгжил, хамгаалал” гэж, “Үр дүн” баганад “Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Арга зам” баганад “Угийн бичгээ хөтлөх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж; **3 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Монголын хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Угийн бичгээ хөтөлдөг гэр бүл” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+3%, 2027: Т+5%, 2028: Т+8%, 2029: Т+10%, 2030: Т+15%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж. Мөнхсоёл гишүүн байхгүй байна.

Мөнхсоёл гишүүний гаргасан саналын томъёоллыг дэмжье гэсэн санал хураалт.

Гишүүдийн 33.3 хувь нь дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.2.1.4 дэх дэд заалтад доор дурдсан агуулгатай шалгуур үзүүлэлтүүд нэмэх:

“Шалгуур үзүүлэлт” баганад “Эрүүл мэндийн салбарт зарцуулж буй зардлын ДНБ-нд эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 3.2” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 3.5, 2027: 5, 2028: 5.5, 2029: 6, 2030: 6” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн статистик, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Үндэсний тооцоо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам, Сангийн яам” гэж, мөн “Шалгуур үзүүлэлт” баганад “Засгийн газрын нийт төсөвт эрүүл мэндийн эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 8.3” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 10, 2027: 11, 2028: 11.5, 2029: 12, 2030: 12” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн статистик, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Үндэсний тооцоо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам, Сангийн яам” гэж

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан. Мөнхсайхан гишүүний микрофоныг нээе.

Т.Мөнхсайхан: Байнгын хорооны дарга гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгэхээр манай эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилт ДНБ-ий 6 хувиас доошгүйд хүрч байж энэ санхүүжилтийн асуудал шийдэгддэг гэдэг энэ ОУБ-ын тооцоо судалгаануудыг бүгдээрээ байгаа. Тэгээд манай улсын хувьд энэ жилийн хувьд 3 хувьтай байсан боловч ирэх оны төсөв өргөн баригдсан 2.6 болж бүүр буурсан байгаа. Тэгээд ЭМЯ, Хөдөлмөр хамгааллын яам, Сангийн яамныхан нийлээд ирэх оны цалинг 75 хүртэл хувиар нэмэгдүүлнэ гэдэг ийм гэрээ контракт хийчихсэн ийм хэмжээнд нэмэгдүүлэхэд 2026 оны эрүүл мэндийн салбарт зарцуулагдах төсөв ДНБ-ий 3.5 хувьд хүрэхгүйгээр боломжгүй ээ. Тэгээд энэ гэрээн дээрээ бас тусгахдаа 2027 онд цалингийн доод хэмжээг 3.5 саяд хүргэнэ гэсэн ийм гэрээний заалт бас орсон.

Тэгэхээр энийгээ биелүүлэхэд ДНБ-ий 5 хувьд хүрэхгүйгээр энэ гэрээнүүд биелэгдэх ямар ч боломжгүй ээ. Ингээд 2027 оноос хойш жил бүр 0.5 хувиар нэмэгдэж явах нь чухал байна гэдэг учраас энэ заалтыг оруулсан байгаа. Тэгэхээр ирэх оны энэ хийсэн гэрээнүүдээ биелүүлэхэд энэ их чухал. Нөгөө талаасаа бас энэ 5 жилийн үндсэн чиглэл дотор тусгагдсан байгаа иргэний карманаас гарах зардлыг одоогийн байдлаар 33 хувьтай байгаа нийт зардлын. Энийг 26 хувь болгож бууруулна гэсэн ийм тооцооллыг ингэж тусгасан байгаа. Энийг хангахын тулд хамгийн гол нь даатгалын санд төвлөрч байгаа эх үүсвэрээ нэмэгдүүлэх энэ ДНБ-д эзлэх хувийг нь тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлж явах боломжгүй. Тэгээд нөгөө талаасаа хэдийгээр хэмнэлтүүдийг хийж үр ашигтай зарцуулалтуудыг сайжруулах хэдий ч эх үүсвэрээ нэмэгдүүлэхгүйгээр энэ боломжгүй зүйл юм аа.

Тэгэхээр энийг үе шаттайгаар нэмэгдүүлж явах нь энэ эрүүл мэндийн салбарт цаашдаа гол тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх гол гарц юм аа. Тэгээд энэ маань хөрөнгө оруулалттай хамгийн гол нь ямар ч хамаагүй. Үндсэн чиглэл дээр 30 он хүртэл эрүүл мэндийн салбарт томоохон ямар хөрөнгө оруулалт хийгдэх вэ хэдэн төгрөг тусгах вэ гэдэг нь тодорхой тусчихсан байгаа. Энэ тооцооллууд тодорхой байгаа учраас та бүхэн маань энэ салбарт зарцуулагдах энэ зарцуулагдах ДНБ-д эзлэх хувийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байгаа энэ зарчмын зөрүүтэй саналыг та бүхэн маань дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа эрүүл мэндийн салбарын бодлогын чанартай зарчмын санал байна аа. Энэ дээр нэмэлт тайлбар ер нь ойлгомжтой учраас шаардлагагүй гэж бодож байна. Ийм учраас Мөнхсайхан гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 61.1 хувь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.2.4 дэд заалт нэмэх:

Төслийн **2 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн үр дүнг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.6.7” гэж, “Салбар” баганад “72102 Хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Арга зам” баганад “Анхдагч хуулийн төсөл шинээр боловсруулах, батлуулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, **3 дугаар хавсралтын** үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхойлсон хүснэгтийн “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ахмад настны (55-70 хүртэлх хөдөлмөр эрхлэлтийн түвшин)” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: “38.4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 39.0, 2027: 39.6, 2028: 40.2, 2029: 40.8, 2030: 41.4” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг. Батчимэг гишүүн байгаа юу? Байхгүй байна. Уг нь санал гаргасан гишүүд өөрсдөө ирээд тайлбар өгвөл зөв юм байгаа юм.

Энэнтэй холбоотой. Энэ дээр тайлбар мэдээлэл өгөөч? Микрофон 1.

Б.Найдалаа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул.

Л.Мөнхзул: Ахмад настны тухай хууль гэж Монгол Улсад 2017 онд анхдагч хууль батлагдсан тэгээд 2023, 2024 онд бас нэмэлт өөрчлөлт орсон. Энэ нэмэлт, өөрчлөлтийн гол зохицуулалт нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих. Ялангуяа 65 насанд хүрээгүй тохиолдолд иргэнийг тэтгэвэрт гаргах хүсэлтээ гаргаагүй байгаа тохиолдолд ажлын байрнаас нь тэтгэвэрт гаргахыг ажиллах зүгээс шахахыг хориглосон ийм зохицуулалтууд орсон.

Тэгэхээр тусад нь ингэж бие даасан асуудал бүрээр харилцах хүрээг жижиглэж оруулах нь ахмад настны эрхийн бусад асуудлууд орхигдох учраас бас их явцуурах учраас Нэгдсэн ахмад настны тухай хууль дээр эрх, эрүүл мэнд, боловсрол, цаашдаа цахим дижитал ертөнцөд амьдрах тэр ур чадварыг нэмэгдүүлэх гэх мэт цогцоороо хуулиа явсан нь зүйтэй байх гээд гэсэн ийм үзэл баримтлалын концепцтой хууль байгаа учраас яг ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн хууль гэдэг маань дэндүү явцуу л хууль гарч ирэх гээд байна.

Б.Найдалаа: Баярлалаа ойлголоо. Батчимэг гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 11.1 хувь дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал

Гурав.Тогтоолын төслийн 4 дүгээр хавсралттай холбоотой санал:

Төслийн 4 дүгээр хавсралтын “4.1.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 7 дахь дэд заалтын “Төсөвт өртөг /сая төгрөг/” баганын “468,000.0” гэсний харгалзах мөрний “2026” баганад “-” гэснийг “93,600.0”

гэж, “2027” баганад “93,600.0” гэснийг “81,895.0” гэж, “2030” баганад “210,610.0” гэснийг “128,715.0” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах. Галбадрах гишүүний микрофоныг.

Ж.Галбадрах: Энэ нөгөө АХБ-аас хөнгөлөлттэй зээлээр оруулж ирж байгаа. Боловсролын жилийг угтаад 41 төсөл арга хэмжээг санхүүжүүлэх мөнгө маань байгаа юм 468 тэрбум. Тэгсэн мөртөө энэ 2026 онд боловсролыг дэмжих жил болгоод байхад энд ерөөсөө санхүүжилт тавиагүй. 0 гээд тавьчихсан юм. Энэ алдаатай зүйл байна л гэж ингэж үзэж байна. Тийм учраас энэ дээр нь санал гаргасан түрүүн Боловсролын яам, Сангийн яамнаас бас нягталсан байгаа. Би Сангийн яамыг нэмэлт тайлбар өгсөн гэж хүсэж байна.

Тэгээд ер нь бол манай Байнгын хорооны гишүүд маань одоо бид нар чинь есүүлээ л үлдчихсэн юм чинь, арвуулаа л үлдчихсэн юм шиг байна шүү дээ. Нэг хүн л дутуу өгвөл энэ санал чинь дэмжигдэхгүй болох гээд байгаа байхгүй юу. Тэрийг нь даргыг хэлж өгөөрэй гэж хэлье.

Б.Найдалаа: Асуудал ойлгомжтой учраас Галбадрах гишүүн Сангийн яамнаас нэмэлт тодруулга асуух шаардлагагүй л санагдаж байна. Тэгэхээр Галбадрах гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 55.6 хувь дэмжиж санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 4 дүгээр хавсралтын “4.1.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 7 дахь дэд заалтын “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатарт 41” гэснийг “Улаанбаатарт 31” гэж, мөн хавсралтын “4.2.Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-ийн 7 дахь дэд заалтын “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатарт 41” гэснийг “Улаанбаатарт 31” гэж, “2030” баганад “80” гэснийг “100” гэж, “2026” баганад “0” гэснийг “10” гэж, “2027” баганад “0” гэснийг “35” гэж, “2028” баганад “1” гэснийг “60” гэж, “2029” баганад “1” гэснийг “80” гэж, “2030” баганад “1” гэснийг “100” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах. Та тайлбар нэмж үг хэлэх үү эсвэл яах уу? Тийм. Энэ зүгээр ингээд алдааг залруулсан дэмжих ёстой заалт байна шүү гишүүд ээ. Тэгэхээр Галбадрах гишүүний гаргасан энэ залруулсан саналыг дэмжье гэсэн. Томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 55.6 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 35 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “35” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Боловсролын салбарын багш ажилтныг орон сууцжуулах төсөл” гэж, “Тайлбар”

баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Мөнхтуяа гишүүний микрофоныг нээе.

Ц.Мөнхтуяа: Боловсролын салбарын багш ажилтны орон сууцын нөхцөл нэлээн хүнд байдаг гэдгийг бид нар бас өмнө нь ярьж байсан. Судалгаан дээр ч бас тийм байгаа. Тийм болохоор энэ боловсролын салбарын багш ажилтны орон сууцын орон сууцжуулах төсөл ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах гэсэн ийм санал оруулж байгаа юм аа. Тэгээд энэ саналыг маань бас дэмжиж өгөөрэй. Боловсролын салбарынхан бол орон сууцын ипотекийн зээлд хамрагдъя гэхээр цалин хөлс нь хүрдэггүй ээ. Тэгэхээр энэ дээр төр дэмжлэг үзүүлээд ер нь бол 2026 оныг Боловсролыг дэмжих жил гэж нэгэнт зарласан учраас ядаж энэ асуудлыг нь ч гэсэн дэмжээд явбал уг нь их зүгээр байна гэж бодож байна. Тэгээд та бүхнийг бас дэмжиж өгөхийг хүсье ээ.

Б.Найдалаа: Мөнхтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 27.8 хувь дэмжиж, санал дэмжигдсэнгүй ээ.

Дараагийн санал. Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 36 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “36” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Багшийн хөгжлийн үндэсний төвийн барилга /Улаанбаатар хот/” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Мөнхтуяа гишүүн тайлбар хэлнэ.

Ц.Мөнхтуяа: Манай багш нар бол ер нь яг тийм хөгжлийн төв гэсэн юм байдаггүй ээ. Багшийн мэргэжил дээшлүүлэх төв гээд байгаа шүү дээ. Тэр нь болохоор баахан албан байгууллагууд л байхаас багш нарыг хөгжүүлэх ямар нэгэн тийм ажил зохион байгуулдаггүй гэдгийг багш нар маш их санал шүүмжлэл өгдөг. Тийм учраас яг бодитой багшийн хөгжлийг дэмжих залуу багш нарыг сургах, ахмад багш нарт бас энэ AI сүүлийн үеийн шинэ техник технологитой ажиллах арга барил ийм юм зааж сургадаг газар үнэндээ байхгүй байгаа. Тийм учраас энийг бас гишүүд маань дэмжээд өгөөрэй. Ийм санал оруулсан шүү.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Гишүүдийн 38.9 хувь дэмжиж санал дэмжигдсэнгүй ээ.

Дараагийн санал.

Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 37 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “37” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Боловсролын сургалтын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “ХХААХҮЯ” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Мөнхтуяа гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхтуяа: Манай боловсролын сургалтын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжийн үйлдвэр гэж байдаггүй. Дандаа Хятадаас нэг тийм хямдхан юмнууд төсөл тендерээр оруулж ирээд тэр сандал ширээнүүд нь жил ч болохгүй эвдрээд сарампай болоод унадаг ийм жишээнүүд зөндөө байгаа. Тийм учир түүнээс энийг бас бодолцоод сургалтын хэрэглэгдэхүүний тоног төхөөрөмжийн үйлдвэр барих техник эдийн засгийн үндэс зураг төсөл боловсруулах гэсэн ийм саналыг нэмж оруулж байгаа юм тэгээд энийг маань бас дэмжиж өгөхийг хүсье ээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүний саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 44.4 хувь дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан жагсаалтад доор дурдсан агуулгатай 38 дахь мөр нэмэх.

“Дугаар” баганад “38” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнсний үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “ХХААХҮЯ” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Мөнхтуяа гишүүн бас үг хэлнэ.

Ц.Мөнхтуяа: Цэцэрлэг ЕБС-ийн суралцагчдын үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнсний үйлдвэр гэсэн энэ ТЭЗҮ зураг төсөл боловсруулах гэж санал оруулсан юм аа. Манай хүүхдүүд үдийн хоолондоо үнэхээр чана чанаргүй хүнс хэрэглэж байгааг багш нар ч ярьдаг. Эцэг эхчүүд нь ч гомдол ирүүлдэг. Тэгээд яг Монголдоо дотооддоо энэ хүүхдүүдийнхээ ходоод руу хийж байгаа хоол хүнсийг эрүүл аюулгүй стандарт хангасан ийм үйлдвэр байгуулах шаардлага зүй ёсоор урган гарч байгаа.

Тийм учраас энэ саналыг маань бас дэмжиж өгөөч ээ. Ер нь яг энэ дотооддоо энэ боловсролын салбарын суралцагчдынхаа энэ үдийн хоол цай мөн энэ хэрэглэж байгаа тоног төхөөрөмж, техник энийг бол Монголд бас хийх залуучууд зөндөө байгаа шүү дээ. Бид нар л өөрсдөө төр нь оролцоод энэ тендер нэрээр мөнгө угаах арга юм уу гэж би хардаж байгаа.

Тийм учраас энэ төсөл санаачилгуудыг гаргаж байхад энийг дэмжээд өгөх хэрэгтэй байна л гэж бодож байна шүү. Баярлалаа.

Б.Найдалаа: Мөнхтуяа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Гишүүдийн 38.9 хувь дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд уншиж танилцуулна. Уншиж танилцуулах гишүүн байна уу? Эдийн засгийн байнгын хорооны гишүүн болохоор энийг миний бие уншиж танилцуулъя. 1 дүгээр асуудал хэлэлцэж дууслаа.

12.54 цаг

Дараагийн асуудалд оръё оо. [Дараагийн асуудал ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.](#)

Гишүүд хоёрхон асуудал байгаа. Ажлын хэсэг байгуулах тухай ЭМД-ын тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийж холбогдох санал дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулах асуудал хэлэлцэж байна аа.

Тэгээд ажлын хэсгийг миний бие Найдалаа ахлаад ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллахаар одоогоор санал өгсөн гишүүд нь Х.Болормаа, Д.Ганмаа, Д.Энхтуяа, Л.Энхнасан, С.Эрдэнэбат, С.Зулпхар, Т.Мөнхсайхан нар нэрээ ирүүлсэн байгаа юм аа. Тэгээд нэмэгдэх гишүүн байвал бас болно. Хосбаяр. Гишүүн, Хосбаяр гишүүнийг нэмье.

Ингээд энэ ажлын хэсгийг байгуулах тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4 22.3.13 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.1, 9.4, 9.7 дахь заалтыг хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

ЭМД-ын тухай хуулийн биелэлтэд хяналт, шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Б.Найдлаа, ажлын хэсгийн гишүүд Х.Болормаа, Д.Ганмаа, Л.Энхсайхан, Т.Мөнхсайхан, Д.Энхтуяа, С.Эрдэнэбат, С.Зулпхар, Г.Хосбаяр.

Ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

Ажлын хэсгийн мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтанд тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Холбогдох санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

Санал хураана шүү дээ. Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг дэмжье.

Тогтоолын төслийг баталъя гэдэг томъёоллоор санал хураана. Санал хураалтад бэлдье. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 61.1 хувь нь дэмжиж, тогтоолын төсөл батлагдлаа. Энхтуяа гишүүнийг дэмжсэнээр тооцъё бүртгэе.

Тогтоолын төсөл батлагдлаа.

12.58 цаг

Дараагийн асуудал. Мөн Ажлын хэсгийг байгуулах тухай асуудал байна.

Ажлын хэсгийг энэ бол хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг юм байгаа юм.

Өмнө нь нөгөө хэлэлцсэн асуудалтай холбоотой Байнгын хорооноос гаргасан тогтоол шийдвэрийн биелэлт дээр дүгнэлт санал дүгнэлт гаргах юм байгаа юм.

Энэ их чухал ажлын хэсэг. Одоогоор энэ ажлын хэсэгт орохоор нэрсээ өгсөн гишүүд Ариунзаяа гишүүн, Баатархүү, Ганхүлэг, Зулпхар, Рэгдэл, Энхтуяа нарын гишүүд орохоор саналаа ирүүлсэн байна аа. Энэ дээр нэмж орох гишүүд байвал бас санал гаргаж болно. Галбадрах гишүүнийг энэ ажлын хэсэгт нэмж оруулъя.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя аа.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.7 дахь хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч А.Ариунзаяа, гишүүн ажлын хэсгийн гишүүд Ц.Баатархүү, М.Ганхүлэг, С.Зулпхар, Д.Рэгдэл, Д.Энхтуяа, Ж.Галбадрах нарын

гишүүд. Ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Холбогдох санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

Энэ тогтоолын төслийг баталъя гэдэг томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад бэлдье. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт.

Гишүүдийн 61.1 хувь дэмжиж тогтоолын төсөл батлагдлаа.

Баярлалаа. Өнөөдрийн хурал амжилттай болж өндөрлөлөө. Гишүүддээ баярлалаа. баярлалаа.

12.02 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА